



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

ИХ ӨГӨГДЛИЙН (BIG DATA) САН ҮҮСЭХЭД ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ХАМААРААХ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

2024

ГАРЧИГ

Нэр томъёоны тайлбар толь	3
НЭГ. УДИРТГАЛ	5
1.1 ҮНДЭСЛЭЛ	5
1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	6
1.3 СУДАЛГААНЫ ЗОРИЛТ	6
1.4 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	6
1.5 СУДАЛГААНЫ ТОЙМ	6
ХОЁР. ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ, БЭЛЭН БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ	8
2.1 Төрийн байгууллагуудын өгөгдлийн нөхцөл байдлын судалгаа	8
2.2 Их өгөгдөл, хиймэл оюун ухааныг хөгжүүлэхтэй холбоотой бодлогын бичиг баримт..	11
2.3 Их өгөгдөл, хиймэл оюун ухааны хөгжлийн талаарх олон улсын харьцуулсан судалгаа 13	
2.3.1 Хиймэл оюун ухааны индекс	13
2.3.2 Засаглалын хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс.....	14
2.4 Хиймэл оюун ухааны бодлого, зохицуулалтын талаарх зөвлөмж	16
ГУРАВ. ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ	18
3.1 Хүн, хуулийн этгээдэд хамаараах мэдээллийн талаарх хууль, дүрэм	18
3.2 ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАМААРААХ МЭДЭЭЛЭЛ.....	21
3.3 Хүн, хуулийн этгээдэд хамаараах мэдээлэллийг тодорхойлох	23
3.3.1 Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох болон шифрлэлтийн аргууд	26
3.3.2 Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгох аргыг хэрэглэх	29
3.3.3 Их өгөгдлийн сан байгуулах зарим улсын жишээ.....	31
3.4 Хязгаарлалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгож өгөгдлийн агуулах байгуулах шийдэл	35
3.4.1 Их өгөгдлийн дэд бүтэц.....	35
3.4.2 Хүн, хуулийн этгээдийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон ХҮР системээр дамжуулах шийдэл.....	36
Дүгнэлт.....	39

Нэр томьёоны тайлбар толь

Хүний хувийн мэдээлэл	Хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхул тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;
Хүний эмзэг мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэл гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн тулхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;
Хүнийг тодорхойлох боломжгүй болгох	Хүнийг тодорхойлох боломжгүй болгох гэж мэдээллийг тухайн хүнд хамааруулах боломжгүй болгохыг;
Цахим тодорхойлогч	Цахим тодорхойлогч гэж хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээллийг;
Тодорхойлох боломжгүй болгох	Тодорхойлох боломжгүй (Anonymization) гэдэг нь тухайн өгөгдөл хамаарах хувь хүмүүсийг шууд болон шууд бус байдлаар таних боломжгүй болгож хувиргах үйл явц
Өгөгдөл	Өгөгдөл гэдэг нь дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах болон бусад зорилгоор ашиглаж болох баримт, статистик, мэдээллийн цуглуулга юм.
Өгөгдлийн засаглал	Өгөгдлийн үнэ цэнэ, өгөгдлөөс үүсэх мэдээллийн өгөөжийг нэмэгдүүлэх, түгээх, хамгаалах, хянах зэрэг өгөгдлийн амьдралын тойргийн бүх үйл ажиллагаанд чиглэсэн бодлого, заавар болон мөрдөх стандартыг тодорхойлох үйл ажиллагаа юм. Өгөгдлийн засаглал нь өгөгдлийн эзэмшигч хэн болох, хэн өгөгдөл хандаж болох, хувь хүний болон бусад өгөгдлийн хэрхэн хамгаалах, өгөгдөл ямар стандарт мөрдөхийг тогтоож өгдөг.
Өгөгдлийн удирдлага	Өгөгдлийн засаглалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдах, гүйцэтгэх, хөгжүүлэлт хийх үйл ажиллагаануудыг хэлнэ. Өгөгдлийг ахин ашиглагдахуйц, бусад хуваалцах, өөр өгөгдлүүдтэй нийцэлтэй, илүү уялдаатай байлгах гол суурь нь өгөгдлийн удирдлага болдог. Өгөгдлийн удирдлагагүй засаглал нь хэрэгжүүлэлт байхгүй баримт бичиг болно гэсэн үг юм.
Их өгөгдөл	Их өгөгдөл гэдэг нь уламжлалт өгөгдөл боловсруулах хэрэгслүүдийн боломжкоос хэтэрсэн их хэмжээтэй, төрөл бүрийн өгөгдлийн багцыг хэлнэ.
Мета-өгөгдөл	Өгөгдлийн тухайн мэдээлэл өгөх зориулалттай бүтэцлэгдсэн өгөгдөл бөгөөд өгөгдлийн бүтэц, формат, чанар, агуулга, бэлтгэн

	нийтлэгч, эх үүсвэр, шинэчлэгдэг давтамж, бэлтгэсэн арга зүй, байршил зэрэг бүх талын мэдээллийг агуулна.
Өгөгдийн чанар	Өгөгдлийн нарийвчлал, бүрэн гүйцэд байдал, үнэн зөв байдал, цаг хугацаандаа байгаа эсэх шалгуурыг харуулдаг.
Хиймэл оюун ухаан	Хиймэл оюун ухаан (Artificial Intelligence-AI) нь хүн шиг сэтгэж, сурахаар программчлагдсан машинаар хүний оюун ухааныг загварчлахыг хэлнэ.
YCX	Үндэсний статистикийн хороо
Өгөгдлийг далдлах	Data masking: Жинхэнэ өгөгдлийг бодит мэт боловч танигдах боломжгүй зохиомол өгөгдлөөр орлуулах
Өгөгдөл шуугиан нэмэх	Data Perturbation: Энэ арга нь танигдахаас сэргийлж өгөгдлийг бага зэрэг өөрчлөх
Ерөнхий болгох	Generalization: Нарийвчилсан өгөгдлийг илүү өргөн ангилаал эсвэл мужаар солих
Өгөгдөл дарах	Data Suppression: Дахин таних эрсдэл өндөртэй үед өгөгдлийг бүхэлд нь устгах эсвэл орхих
K-Anonymity	Бүртгэл бүрийг таних шинж чанаруудын хувьд хамгийн багадаа $k-1$ бусад бүртгэлээс ялгах боломжгүй гэдгийг баталгаажуулах
Хуурамч нэршил	Pseudonymization: Хувийн танигчийг хуурамч танигч эсвэл нууц нэрээр солих
Дифференциал нууцлал	Differential Privacy: Нууцлалын баталгааг хангахын тулд өгөгдөл эсвэл асуулгын үр дүнд тохируулсан шуугианыг нэмдэг
Өгөгдлийг нэгтгэх	Aggregation: Өгөгдлийн хураангуй статистик эсвэл нэгтгэсэн утгууд

НЭГ. УДИРТГАЛ

1.1 ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн улс орнууд төрийн их өгөгдлийн санг бүрдүүлж, бодлого боловсруулах, шийдвэр гаргахад ашиглан цаг хугацаа, хөрөнгө, хүн хүч зэрэг нөөцийг хэмнэх, хуваарилалтыг оновчтой болгох замаар үндэсний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, Австрали улс 2015 онд 7 байгууллага (эрүүл мэнд, боловсрол, засгийн газрын төлбөр, орлого, хөдөлмөр эрхлэлт, хүн ам зэрэг)-ын 18 өгөгдлийн санг нэгтгэж халамжийн нөлөө болон засгийн газрын дэмжлэг, нийгмийн хамгааллын бодлогод ашигласан байна¹. Мөн Бүгд найрамдах солонгос улс 2017 онд татвар, эрүүл мэнд, халамж, тэтгэвэрийн мэдээллийн сангийн өгөгдлийг нэгтгэн амьжиргааны түвшин, орлого, тэтгэвэр болон татаасын талаарх бодлого тодорхойлоход ашигласан бол 2015 оноос Хүн амын тооллогыг 14 агентлагийн 25 төрлийн захиргааны бүртгэлд сууриссан аргаар явуулдаг болсон байна².

Монгол Улсын хувьд төрийн байгууллагууд хуулиар олгосон эрх, үүргийн хүрээнд салбарын хэмжээнд анхдагч мэдээллийг бүрдүүлэх, бүртгэл мэдээлэл хөтлөх чиглэлээр өөрсдийн нөөц боломж, чадавхын хэмжээнд мэдээллийн санг бүрдүүлж байна.

Мэдээлэл хариуцагч байгууллагууд хооронд харилцан мэдээлэл солилцох, хуваалцах, дахин ашиглахад мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгон дамжуулах, ашиглах нөхцөл бүрдээгүй нь өгөгдөл, мэдээлэл цуглуулахад хүндрэл үүсгэж байна.

Цахим шилжилт хурдацтай өrnөж, мэдээллийн технологи, түүний хэрэглээ улам бүр тэлсээр байгаа манай улсад нийгмийн салбар бүрийн их өгөгдлийн мэдээлэл цугларсаар байгаа бөгөөд түүнийг боловсруулж төр хувийн хэвшлийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад ашиглах, ухаалаг, оновчтой, шинжлэх ухаанч шийдвэр гаргах нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтооолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дугаар зорилтын 1 дүгээр үе шат, хүрэх үр дүнгийн 2 дахь заалтад “Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө.” гэж, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.5 дахь заалтад “Их өгөгдөл сууриссан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.” гэж тус тус заасан.

Энэ хүрээнд төрийн байгууллагуудын бүрдүүлж, ашиглаж буй өгөгдөл, мэдээллийг нэгтгэн, нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээний үр дүнд их өгөгдөл бий болгоход шаардлагатай арга, хэрэгслийг тодорхойлох зорилгоор “Их өгөгдлийн (big data) сан” үүсгэх тухай шийдвэр (Засгийн газрын тогтоол 2023.11.18, 403 дугаар) - ийг Монгол улсын засгийн газар гаргасан байна.

Их өгөгдлийн сан үүсгэхдээ тухайн иргэнийг тодорхойлох боломжгүй болгож төрийн байгууллагуудын бусад мэдээлэлтэй холбосноор төрөөс гаргаж байгаа зарим шийдвэрийг урьдчилан шинжлэх, дүгнэх боломжийг хиймэл оюун ашиглаж тооцох урьдчилсан

¹ <https://www.abs.gov.au/about/data-services/data-integration/integrated-data/multi-agency-data-integration-project-madip>

² <https://kostat.go.kr/menu.es?mid=a20208050000>

нөхцөлийг бүрдүүлнэ. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар “6.2.5.хүний тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, статистикийн мэдээлэл бэлтгэх.” гэж заасан байдаг. Энэ хуулийн хүрээнд мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй байдлаар өгөгдлийн сан үүсгэхэд энэхүү судалгаа чухал ач холбогдолтой юм.

Төрийн их өгөгдлийн сан байгуулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулалт хийх нь нөхцөлийг бүрдүүлснээр дээрх төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ач холбогдолтой.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, дүн шинжилгээ хийхэд шаардлагатай хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг төрийн байгууллагуудын бүрдүүлж, ашиглаж буй өгөгдөл, мэдээллийн сангийн судалгаанаас тодорхойлох, хязгаарлалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох хувилбарт шийдлийг гаргахад чиглэнэ.

1.3 СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

- Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэхэд шаардлагатай хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох;
- Хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, загварыг гаргах;
- Хязгаарлалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох гадны улсын туршлагыг судлах;
- Манай улсын нөхцөл байдалд тохирсон хувилбарт шийдлийг гаргах;
- Ажлын даалгаварт тусгасан судалгааны үр дүн, хувилбарт шийдэл бүхий эцсийн тайлан хүлээлгэн өгөх;

1.4 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороо хамтран боловсруулсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийн сан, тэдгээрийн төрийн их өгөгдлийн санд нэгтгэх суурь нөхцөлийн бэлэн байдлын үнэлгээ /тоон болон чанарын/, мэдээллийн сангийн мета-өгөгдлийн үзүүлэлтийн асуултгыг мета-өгөгдлийн судалгаа / <https://metadata.nso.mn/> /-aac хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлж, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлалыг гаргана.

1.5 СУДАЛГААНЫ ТОЙМ

Өгөгдлийн сангийн зорилго, хамрах хүрээ, түүний ашиглалт, өгөгдлийн эх сурвалж, өгөгдлийн өсөлтийн хэмжээ болон ашиглалтыг хугацаа, мэдээллийн санг үүсгэн бүрдүүлсэн хууль зүйн үндэслэл, дүрэм журам, мэдээлэл хариуцагчаас үндсэн системд нийлүүлж буй мэдээлэл, мэдээлэл хариуцагч байгууллага, өгөгдлийн сангийн нэр, нэгтгэн гаргаж буй статистик мэдээллүүдийг мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийн сан, тэдгээрийн төрийн их өгөгдлийн санд нэгтгэх суурь нөхцөлийн бэлэн байдлын үнэлгээ

/тоон болон чанарын/, мэдээллийн сангийн мета-өгөгдлийн үзүүлэлтийн асуулга бүхий мета-өгөгдлийн судалгаа / <https://metadata.nso.mn/-aac> тодорхойлж гаргасан. Хавсралт -2

Ажлын даалгаварт тусгасан бусад төрөлжсөн мэдээллийн сангаас мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж буй мэдээлэл, олон нийтэд нээлттэй мэдээллийн багц, салбарын тайлан, бүтэцгүй болон хагас бүтэцлэгдсэн нөөц, текст, баримт бичиг, мультимедиа /зураг, аудио, видео/ файлууд, тэргүүлэх судалгаа, бодлогын асуултууд зэрэг нь мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийн сан, тэдгээрийн төрийн их өгөгдлийн санд нэгтгэх суурь нөхцөлийн бэлэн байдлын үнэлгээ /тоон болон чанарын/, мэдээллийн сангийн мета-өгөгдлийн үзүүлэлтийн асуулга бүхий мета-өгөгдлийн судалгаа / <https://metadata.nso.mn/-nd> тусгагдаагүй байсан болно.

Тодорхойлсон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээлэл их өгөгдлийн сан бүрдүүлэх зорилго, хүн хуулийн этгээдийн ашиг, сонирхлыг хөндөөгүй, шаардлагад нийцэж байна. Харин мэдээлэл үнэн зөв, бодитой, хүртээмжтэй, хэрэгцээтэй, ойлгомжтой байдал, өгөгдлийн хамаарал, үнэ цэнтэй өгөгдлий тодорхойлох үйл ажиллагаа нь мета-өгөгдлийн сангаас тодорхойлох боломжгүй бөгөөд энэ нь их өгөгдлийн нээлттэй сан бүрдүүлж, өгөгдлийн шинжилгээ хийх үе шатанд тодорхойлох боломжтой ажлууд болно.

ХОЁР. ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ, БЭЛЭН БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

2.1 Төрийн байгууллагуудын өгөгдлийн нөхцөл байдлын судалгаа

Төрийн байгууллагуудын бүрдүүлж, ашиглаж буй өгөгдөл, мэдээллийг нэгтгэн, нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээний үр дүнд их өгөгдөл бий болгоход шаардлагатай арга, хэрэгслийг тодорхойлох зорилгоор Үндэсний статистикийн хорооноос 2022 онд төрийн 38 байгууллагын 75 өгөгдлийн санг судалгаанд хамруулсан. Өгөгдлийн сан бүхий төрийн байгууллагуудыг салбараар ангилж үзэхэд эдийн засгийн чиглэлийн 12 байгууллагын 22 сан, нийгмийн чиглэлийн 13 байгууллагын 27 сан, байгаль орчны чиглэлийн 5 байгууллагын 14 сан, үлдсэн 8 байгууллагын 12 сан нь бүртгэл, шинжлэх ухаан зэрэг бусад чиглэлийн сангуд байна.

Эдгээр өгөгдлийн сангуд нь эдийн засаг, нийгмийн хамгаалал, байгаль орчин, шинжлэх ухааны чиглэл бүхий цахим үйлчилгээ, хяналт, тайлан мэдээ гаргах, судалгаа шинжилгээнд ашиглах, архив үүсгэх гэсэн нийтлэг зорилгоор ашиглаж байна.

Судалгаанд хамрагдсан 75 өгөгдлийн сангийн 69% нь статистик мэдээлэл нэгтгэн гаргах, 72% нь боловсруулалт, дүн шинжилгээ хийх, 39% нь шийдвэр гаргалт буюу бодлогын түвшинд өгөгдлийн сан тус бүрдээ ашиглагдаж байна. Судалгааны үр дүн, хэрэгцээ шаардлагаас үзэхэд өгөгдлийн санд дахь өгөдөл, мэдээлийн давхардал их, нэгдсэн ангилал кодын хэрэглээ дутмаг, өгөгдлийн сан хоорондын уялдаа хангагдаагүй, тус бүрдээ статистик мэдээ, боловсруулалт, дүн шинжилгээ хийж байгаа нь үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Мөн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, хуваалцах, дахин ашиглахад мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгон дамжуулах, ашиглах нөхцөл бүрдээгүй нь мэдээлэл хариуцагчдад хүндрэл үүсгэж байна.

Төрөл бурийн эх сурвалжаас авсан тодорхойлох боломжгүй өгөгдлийг өгөгдлийн агуулахад нэгтгэхэд өгөгдлийн холбоо хамаарлыг алдагдуулахгүй байх нь чухал. Иймд түлхүүр болж байгаа атрибутиг шифрлэх эсвэл хуурмаг нэрээр сольж өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг хангах боломжтой. Гэхдээ өгөгдлийн эзнийг буцааж тодорхойлохгүй байх талын механизмыг хийхэд анхаарах хэрэгтэй. УСХ-ны судалгаагаар төрийн өгөгдлийн сангуд дахь үзүүлэлтээс харахад сангудыг хооронд нь уялдуулах боломж бүхий түлхүүр буюу идентификатор (unique identifier) нь аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүний регистрийн дугаар байна.

26 байгууллагын 44 өгөгдлийн санд регистрийн дугаар гэсэн үзүүлэлт байгаа нь эдгээр санг хооронд нь уялдуулах, холбох боломжтой байна. Хүснэгт 2.1-д уялдуулах боломжтой өгөгдлийн сангудын жагсаалтыг түлхүүр талбараар нь харууллаа.

Хүснэгт 2.1. Уялдуулах боломжтой өгөгдлийн сангудын жагсаалт

	Байгууллагын нэр		Өгөгдлийн бүрэлдэхүүний нэр	сан/дэд		Үзүүлэлтийн нэр (өгөгдлийн сан дахь нэршил)
1	Ашигт малтмал, газрын тосны газар	1	Уул уурхайн компьютержсан кадастрын систем	1	Өргөдөл гаргагчийн регистр	
				2	Эзэмшигчийн регистр	
				3	Барьцаалагчийн регистр	

					4	Эзэмшигчийн регистр
2	Барилга, хот байгуулалтын яам	2	Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сан	5	AАНБ-ын регистр, Регистр	
3	Боловсролын ерөнхий газар	3	Боловсролын салбарын мэдээллийн систем - ЕБС	6	Регистр	
		4	Боловсролын салбарын мэдээллийн систем - СӨБ	7	Регистр	
		5	Дээд Боловсролын удирдлагын мэдээллийн систем	8	Регистр	
		6	МБСС-ын мэдээллийн нэгдсэн систем	9	Регистрийн дугаар	
4	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	7	Монгол хүүхдийн хөгжлийн судалгааны цахим хувилбар	10	Регистрийн дугаар	
5	Гаалийн ерөнхий газар	8	Гаалийн мэдүүлгийн сан	11	Гаалийн зуучлагч байгууллагын ажилтны регистрийн №	
				12	Гэрээний ААН-ийн регистр №	
6	Гадаадын иргэн, харьяатын газар	9	Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох программ хангамж	13	Регистр	
		10	Монгол Улсын хилээр нэвтрэч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийн нэгдсэн систем	14	РД	
7	Зам, тээврийн хөгжлийн яам	11	Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан	15	Регистрийн дугаар	
8	Монголбанк	12	Зээлийн мэдээллийн сан	16	Хүний регистрийн дугаар	
				17	Байгууллагын регистрийн дугаар	
9	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	13	Үйлдвэрлэлийн осол, Хурц хордлого бүртгэл	18	Иргэний регистрийн дугаар	
				19	Регистрийн дугаар	
		14	Шилэн хяналтын цахим систем	20	Шалгуулагч этгээд бүртгэл, албан хаагч - Регистор	
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	15	Нийгмийн Даатгалын мэдээллийн сан	22	Регистрийн дугаар	
11	Оюуны өмчийн газар	16	Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын мэдээллийн сан	23	Регистрийн дугаар	
		17	Зохиогчийн эрхийн мэдээллийн сан	24	Регистрийн дугаар	
12	Сангийн яам	18	DMFAS мэдээллийн сан	25	Байгууллагын улсын бүртгэлийн дугаар	
				26	Байгууллагын улсын бүртгэлийн дугаар	
		19	PMMIS	27	Регистрийн дугаар	

		20	ЕТайлангийн мэдээллийн сан	28	Байгууллагын улсын бүртгэлийн дугаар
		21	Иргэний мэдээллийн сан, Хуулийн этгээдийн мэдээллийн сан	29	Байгууллагын улсын бүртгэлийн дугаар
				30	Регистрийн дугаар
		22	Төсвийн мэдээллийн сан	31	Регистрийн дугаар
		23	Хүний нөөцийн систем	32	Регистрийн дугаар
		24	Шилэн дансны нэгдсэн систем	33	Байгууллагын улсын бүртгэлийн дугаар
				34	Регистрийн дугаар
		25	Эдийн засгийн мэдээллийн сан	35	Регистрийн дугаар
13	Санхүүгийн зохицуулах хороо	26	Зохицуулалттай этгээдээс авах тайлан, нэгтгэлийн сан, Санхүүгийн зохицуулах хорооны тайлан, нэгтгэлийн систем	36	Регистрийн дугаар
		27	Тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан / Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем/	37	Регистр
14	Татварын ерөнхий газар	28	Татварын удирдлагын нэгдсэн систем	38	Өмчлөгчийн регистр
				39	Регистрийн дугаар
				40	Объектын улсын бүртгэлийн регистрийн дугаар
				41	Харилцан хамарагчийн регистрийн дугаар
				42	Улсын бүртгэлийн регистрийн дугаар
15	Төрийн албаны зөвлөл	29	Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем	43	Гэр булийн гишүүний Регистрийн дугаар
				44	Регистрийн дугаар
				45	Байгууллагын регистрийн дугаар
16	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	30	Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны тооллогын бүртгэлийн сан	46	Регистрийн дугаар
17	Улсын бүртгэлийн ерөнхий газар	31	Иргэний бүртгэлийн мэдээллийн сан	47	Төлбөр төлсөн иргэний регистрийн дугаар
		32	Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан	48	Регистрийн дугаар
		33	Эд хөрөнгийн мэдээллийн сан	49	Хуулийн этгээдийн регистр
				50	Иргэн Хуулийн этгээдийн регистр
18	Ус цаг, уур орчны судалгаа мэдээллийн хурээлэн	34	Байгаль орчны статистик мэдээллийн сан	51	Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн дугаар
19	Үндэсний геологийн алба	35	Геомэдээллийн систем	52	Регистрийн дугаар
20	Үндэсний data төв	36	Төрийн мэдээлэл солилцооны системийн лог бүртгэл	53	Үйлчлүүлэгч байгууллагын дугаар

21	Үндэсний итгэмжлэлийн төв	37	Монгол улсын хэмжээнд итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (тоо, төрлөөр)	54	Улсын дугаар бүртгэлийн
22	Хот байгуулалт, хөгжлийн газар	38	Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем	55	Регистрийн дугаар
23	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	39	Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сан(wais)	56	Регистр
		40	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан (heb2017)	57	Та регистрийн дугаараа хэлнэ үү?
24	ЦЕГ, Мэдээлэл шуурхай удирдлагын төв	41	Дуудлага мэдээллийн өгөгдлийн сан	58	Регистрийн дугаар
25	Эрүүл мэндийн хөгжлийн төв	42	Хүн амын төрөлтийн мэдээлэл	59	Эхийн регистр
		43	Хүн амын өвчлөл, нас баралтын мэдээллийн сан	60	Регистрийн дугаар
		44	Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан	61	Регистрийн дугаар
26	Эрчим хүчний яам	62		Регистрийн дугаар	

Судалгааны үр дүнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороо хамтран төрийн байгууллагуудын үүсгэсэн өгөгдлийг багц (мэдээллийн сан), хүснэгт, үзүүлэлт, ангилал, код, тэдгээрийг цуглуулж байгаа маягт, асуулгын хуудасны мета элементүүдийг харуулах, өгөгдлийн сангийн үзүүлэлт, түүнд ашиглаж байгаа ангилал, кодын уялдааг харах зорилготой төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлсэн. Холбоос: <https://metadata.nso.mn/>

Монгол Улсын Засгийн газар нээлттэй өгөгдлийн бодлогыг хэрэгжүүлэх тал дээр тодорхой ахиц давшил гаргасан. Тухайлбал Засгийн газар 2017 онд “Open Data Mongolia” порталыг ажиллуулж, олон төрлийн төрийн нээлттэй мэдээллийг авах боломжтой болсон. Засгийн газар мөн хэд хэдэн нээлттэй мэдээллийн каталогийг нийтэлсэн бөгөөд тэдгээр нь байгаа мэдээллийн төрлүүд, тэдгээрт хэрхэн хандах талаар мэдээлэл өгдөг. Гэсэн хэдий ч Монгол Улсын Нээлттэй мэдээллийн бодлогыг хэрэгжүүлэхэд хийх ажил их байна. Засгийн газар илүү олон тоо баримтыг үргэлжлүүлэн нийтлэх шаардлагатай бөгөөд өгөгдлийг олох, ашиглахад хялбар болгох хэрэгтэй. Мөн төрөөс иргэд, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагуудын нээлттэй мэдээллийн хэрэглээг дэмжих шаардлагатай байна.

2.2 Их өгөгдөл, хиймэл оюун ухааныг хөгжүүлэхтэй холбоотой бодлогын бичиг баримт

Хиймэл оюун ухаан нь засгийн газруудын төрийн үйлчилгээг шинэчлэх төлөвлөгөөний нэг хэсэг болж байгаа бөгөөд хиймэл оюун ухааныг ашиглах талаар зөв шийдвэр гаргах чадавх, тогтолцоо, ур чадвар, нөөц, дэд бүтцийг бий болгоход анхаарах шаардлагатай байдаг. Хиймэл оюун ухааныг (AI) хөгжүүлэх, ашиглахтай холбоотой олон улсын бодлого, дүрэм журмууд гарч байгаа бөгөөд эдгээр бодлого, зохицуулалт нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг ч ерөнхийдөө хиймэл оюун ухааныг аюулгүй, ёс зүйтэй, хариуцлагатай байдлаар хөгжүүлж, ашиглахад чиглэдэг. Монгол улсын хувьд хиймэл оюун ухаан, их өгөгдлийн зохицуулалтын талаар дараах бодлого, хууль тогтоомж, шийдвэрүүд байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- “ЦАХИМ ҮНДЭСТЭН” дунд хугацааны зорилтот хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 11-р сарын 08 өдрийн “Их егегдлийн (big data) сан” үүсгэх тухай 401 дүгээр тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.6-д заасныг үндэслэн “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ыг баталж нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем”-д тогтоосон хугацаанд байршуулахыг холбогдох байгууллагын удирдлагад үүрэг болгосон.

“Цахим үндэстэн” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт:

- Мэдээллийн технологи, харилцаа холбооны өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангана.
- Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, шуурхай, ил тод **цахим засаглалыг хөгжүүлнэ**.
- Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэн, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, **хүртээмжтэй байдлыг хангана**.
- Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болно.
- Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмын интернэт, үүлэн технологи, блокчэйн зэрэг орчин үеийн технологид суурилсан системүүдийг хөгжүүлж, электроникийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж **инновац, үйлдвэрлэлийг дэмжих замаар дижитал эдийн засгийг бий болгоно**.
- Нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, **өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлнэ** гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

2022 оны тавдугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хуулиар хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай Монгол Улсын хуулиас гадна Монгол Улсад AI & Big Data-тай холбоотой хэд хэдэн хууль тогтоомжууд байна. Үүнд:

- Цахим гарын үсгийн тухай
- Кибер аюулгүй байдлын тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль

2.3 Их өгөгдөл, хиймэл оюун ухааны хөгжлийн талаарх олон улсын харьцуулсан судалгаа

Өгөгдөлгүйгээр хиймэл оюун ухааны системийг хөгжүүлэх боломжгүй. Иймд их өгөгдлийн сан бүрдүүлэх нь байгууллага, судлаачдад илүү сайн шийдвэр гаргах, шинийг санаачлах, янз бүрийн салбарт үр ашгийг дээшлүүлэх боломжийг олгох, орчин үеийн өгөгдлийн аналитик, технологийн бүрэн боломжийг ашиглахад зайлшгүй шаардлагатай.

Олон улсад дараах 2 индексээр улс, орнуудын хиймэл оюуны хөгжлийг харьцуулан дүгнэж байна. Үүнд:

- Засаглалын хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс
- Хиймэл оюуны индекс

2.3.1 Хиймэл оюун ухааны индекс

Хиймэл оюуны индекс(AI индекс) нь хиймэл оюун ухааны судалгаа, хөгжүүлэлт, ашиглалтын өнөөгийн байдал, нэвтрүүлэлтийн талаарх иж бүрэн тоймыг гаргах зорилготой олон улсын жил бүрийн харьцуулсан тайлан юм. Уг тайландаа техникийн дэвшил, эдийн засгийн үр нөлөө, бодлогын хөгжил, нийгэмд үзүүлэх үр дагавар гэх мэт хиймэл оюун ухааны талаарх дүн шинжилгээ, өгөгдлийг багтаадаг.

AI индексийн тайлангийн үндсэн зорилго нь:

- **Ахиц дэвшлийн үнэлгээ:** Энэхүү тайлан нь хиймэл оюун ухааны судалгаа, хөгжүүлэлт, тэр дундаа технологи, алгоритм, хэрэглээний салбарт гарсан ололт амжилтыг үнэлэх зорилготой юм. Энэ нь цаг хугацааны ахиц дэвшлийг хянахад тусалдаг ба сайжруулалтын хурдны талаарх ойлголтыг өгдөг.
- **Бодлого болон шийдвэр гаргалтыг мэдээлэх:** Бодлого боловсруулагчид, судлаачид, салбарын удирдагчид болон бусад оролцогч талууд хиймэл оюун ухаантай холбоотой зохицуулалт, хөрөнгө оруулалт, стратеги төлөвлөлтийн талаар мэдээлэлтэй шийдвэр гаргахын тулд хиймэл оюуны индексийг ашиглах боломжтой. Бодлогын хэлэлцүүлгийг чиглүүлэх үүднээс хиймэл оюун ухааны төлөв байдлын талаарх өгөгдөл тулгуурласан хэтийн төлөвийг өгдөг.
- **Бенчмаркинг:** AI индекс нь судлаачид болон дадлагажигчдад хиймэл оюун ухааны янз бүрийн систем, загваруудын гүйцэтгэлийг харьцуулах боломжийг олгодог жишиг шинжилгээний өгөгдлийг агуулж болно. Энэ мэдээлэл нь янз бүрийн аргын харьцангуй давуу болон сул талуудыг ойлгоход үнэ цэнэтэй юм.
- **Нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ:** Уг тайландаа ёс зүй, шударга байдал, ил тод байдалтай холбоотой асуудлуудыг багтаасан хиймэл оюун ухааны нийгэмд үзүүлэх нөлөөг судалж болно. Эдгээр үр дагаврыг ойлгох нь хариуцлагатай AI технологийг хөгжүүлэхэд маш чухал юм.
- **Боловсролын нөөц:** AI индекс нь хиймэл оюун ухааны салбарын гол чиг хандлага, сорилт бэрхшээл, боломжуудын талаар иж бүрэн тойм өгөх боловсролын эх сурвалж болж чадна. Үүнийг оюутнууд, сурган хүмүүжүүлэгчид болон хиймэл оюун ухааны хөгжлийн талаар мэдээлэл авах сонирхолтой хүн бүр ашиглах боломжтой.

AI индекс нь хиймэл оюун ухааны судалгаа, хөгжлийн төлөв байдлыг хянах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх хэрэгсэл болж, мэдээлэлтэй шийдвэр гаргах, бодлого боловсруулах, хиймэл оюун ухааны нийгэмд үзүүлэх нөлөөг илүү сайн ойлгоход хувь нэмэр оруулдаг.

2.3.2 Засаглалын хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс

Хиймэл оюун ухаан(AI) нь засгийн газруудын төрийн үйлчилгээг шинэчлэх төлөвлөгөөний нэг хэсэг болж байна. Үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээний хүртээмжийг шударгаар хангах, иргэдийн үйлчилгээний туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор хиймэл оюун ухааныг ашиглах байна. Гэсэн хэдий ч хиймэл оюун ухааныг үйлчилгээнд нэвтрүүлэхэд засгийн газар яг ямар үндэс суурь шаардлагатай вэ, үүнээс гадна хиймэл оюун ухааныг төрд үр дүнтэй, хариуцлагатай ашиглахад юу шаардлагатай вэ гэдгийг ойлгохгүй байна. Оксфордын Insights компаниас гаргадаг засаглалын хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс нь энэхүү ойлгомжгүй байдлыг арилгахыг эрмэлздэг.

Засаглалын газрын хиймэл оюун ухааны бэлэн байдлын индексээр тухайн Засгийн газар төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд хиймэл оюун ухаан нэвтрүүлэхэд хэр бэлэн байна вэ гэсэн асуултад хариулахыг зорьж байна. Энэ асуултад хариулна гэдэг нь хиймэл оюун ухааны бэлэн байдалд хувь нэмрээ оруулж буй засгийн газрын болон технологийн дэвшлийн олон хэмжүүрийг хэмждэг гэсэн үг юм. Үүссэн индекс нь засгийн газруудад хиймэл оюун ухааныг ашиглах талаар зөв шийдвэр гаргах чадавх, тогтолцоо, ур чадвар, нөөц, дэд бүтцийг бий болгох замаар үйлчилгээндээ хиймэл оюун ухаан нэвтрүүлэхэд бэлтгэхэд нь туслах зорилготой юм.

Индексийн нийт оноог засгийн газар, технологийн слбар, өгөгдөл ба дэд бүтэц гэсэн гурван тулгуурт хүчин зүйлийн 10 хэмжигдэхүүний 39 үзүүлэлтээр гаргадаг. Үүнд:

Засаглалын газрын тулгуур хүчин зүйл: Энэ тулгуур нь хиймэл оюун ухааны талаарх засгийн газрын стратегийн алсын хараа, зохицуулалтын тогтолцоо, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх, ашиглах чадавхийг хэмждэг.

Технологийн салбарын тулгуур хүчин зүйл: Энэ тулгуур нь тухайн улсын технологийн салбарын төлөвшил, хиймэл оюун ухааны шийдлийг хөгжүүлэх, нэвтрүүлэх чадавх, хиймэл оюун ухааны ур чадварын бэлэн байдлыг хэмждэг.

Өгөгдөл, дэд бүтцийн тулгуур хүчин зүйл: Энэ тулгуур нь өндөр чанартай өгөгдлийн хүртээмж, тухайн улсын өгөгдлийг хадгалах, боловсруулах дэд бүтэц, засгийн газрын өгөгдлийг үр дүнтэй ашиглах чадварыг хэмждэг.

Засгийн газрын хиймэл оюун ухаанд бэлэн байх хамгийн чухал хүчин зүйлүүд нь:

- Ундэсний хиймэл оюун ухааны стратеги байгаа эсэх
- Өгөгдөл, дэд бүтцийн бэлэн байдал, хүртээмж
- Төрийн байгууллагын ажиллах хүчиний ур чадвар, чадавх юм.

39 үзүүлэлтээс үзүүлбэл:

Засгийн газрын тулгуур хүчин зүйл

- AI стратеги
- Зохицуулалт
- Ёс зүй
- Дижитал багтаамж
- AI худалдан авалт
- Төрийн үйлчилгээн дахь хиймэл оюун ухаан

Технологийн секторын тулгуур хүчин зүйл

- AI инноваци

- AI ур чадвар
- AI хөрөнгө оруулалт
- Өгөгдлийн бэлэн байдал
- Өгөгдлийн төлөөлөх байдал
- Өгөгдлийн дэд бүтэц

Өгөгдөл, дэд бүтцийн тулгуур хүчин зүйл

- Үүлэн тооцоолол
- Их өгөгдөл
- Интернет холболт
- Цахим засаглал
- Засаглалын өгөгдлийн нээлттэй байдал

Индекс жил бүр шинэчлэгдэг бөгөөд 2023 оны хэвлэлд 190 орныг жагсаажээ. Уг индексийг АНУ тэргүүлж Сингапур, Их Британи, Финланд улсууд удаалсан байна. Зарим улсууд дорвитой арга хэмжээ авсан нь харагдаж байна. Энэтхэг улс 2021 онд 51 дүгээр байрт орж байсан бол 2023 онд 40 дугаар байранд жагсжээ.

Хиймэл оюун ухааны бэлэн байдлын хувьд дэлхийн хөгжиж буй улс орнууд, ялангуяа буурай хөгжилтэй орнууд хөгжингүй орнуудаас хоцорч байгаа нь хүснэгт 1-ээс харагдаж байна. Төрийн үйлчилгээнд хиймэл оюун ухааны ашиглалт ихэнх засгийн газруудад анхан шатны түвшинд байгаа бөгөөд хэрэгжилтийг сайжруулахад хиймэл оюун ухаан болон их өгөгдлийн бэлэн байдлын талаар ойлголттой болгох, энэ чиглэлээр чадавхийг бэхжүүлэх ажлуудыг зохион байгуулах нь чухал суурь арга хэмжээнүүд болно. Индексийг давуу болон дутагдалтай талуудыг тодорхойлж, хэрэгжилтийг хамгийн сайнаар хангахад ашигладаг.

Хүснэгт 1. Улсуудын эрэмбэ

Global Ranking	Country	Total score	Government Pillar	Technology Sector Pillar	Data & Infrastructure Pillar
1	United States of America	84.80	86.04	81.02	87.32
2	Singapore	81.97	90.40	66.19	89.32
3	United Kingdom	78.57	82.50	68.80	84.42
4	Finland	77.37	88.34	60.36	83.39
5	Canada	77.07	85.30	64.73	81.17
6	France	76.07	84.03	60.40	83.80
7	Republic of Korea	75.65	87.55	54.36	85.02
8	Germany	75.26	80.78	63.28	81.72
9	Japan	75.08	82.76	56.85	85.61
10	Netherlands	74.47	78.90	61.96	82.55
109	Mongolia	38.99	35.83	27.71	53.43

Монгол улс 193 орноос 109-т эрэмбэлэгдсэн бөгөөд нийт оноо нь дэлхийн дунджаас 7 оноогоор доогуур ыөгөөд өгөгдөл, дэд бүтцийн тулгуур хүчин зүйл нь засаглалын болон технологийн хүчин зүйлээс илүү өндөр үзүүлэлтийг харуулж байна.

Засаглалын хиймэл оюун ухаан ба их өгөгдлийн бэлэн байдлын индекс нь төрийн үйлчилгээнд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхээр төлөвлөж буй засгийн газруудад үнэ цэнэтэй мэдээлэл юм. Уг тайлан нь засгийн газрын хиймэл оюун ухааны бэлэн байдалд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн талаарх ойлголтыг агуулсан бөгөөд засгийн газрууд бэлэн байдлаа хэрхэн сайжруулах талаар зөвлөмж өгдөг.

Тус тайландаа засгийн газруудад дараах зүйлийг зөвлөж байна. Үүнд:

- *Хиймэл оюун ухааны үндэсний стратегийг боловсруулж хэрэгжүүлэх*
- *Өгөгдөл болон дэд бүтцэд хөрөнгө оруулах*
- *Төрийн албан хаагчдын ур чадвар, чадавхийг сайжруулах*
- *Хиймэл оюун ухааны талаарх олон нийтийн оролцоо, мэдлэгийг дээшилүүлэх*

2.4 Хиймэл оюун ухааны бодлого, зохицуулалтын талаарх зөвлөмж

Хиймэл оюун ухааны бодлого гэдэг нь хиймэл оюун ухааны технологийг хөгжүүлэх, байршуулах, ашиглахтай холбоотой дүрэм, заавар, зохицуулалтыг хэлнэ. Эдгээр бодлогыг үндэсний, бүс нутгийн, олон улсын зэрэг янз бүрийн түвшинд боловсруулж болно. Хиймэл оюун ухааны бодлого нь хиймэл оюун ухааны ёс зүй, хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн асуудлуудтай холбоотой өргөн хүрээний асуудлыг шийддэг. Хиймэл оюун ухааны бодлого, зохицуулалтад дараах асуудлуудыг авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. **Хиймэл оюун ухааны үндэсний стратегийг бий болгох:** Энэхүү стратеги нь хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, ашиглах улс орны хэтийн төлөв, бодлого зохицуулалтыг боловсруулахад чиглүүлэх гол зарчмуудыг тусгах ёстой.
2. **AI-ийн эрсдэл, ашиг тусыг тодорхойлох:** Энэ нь хиймэл оюун ухаанаас учирч болох хор хөнөөл, боломжит үр ашгийг үнэлэхэд хамаарна. Үр дүнтэй бодлого зохицуулалтыг бий болгохын тулд эрсдэл, ашиг тусыг хоёуланг нь ойлгох нь чухал юм.
3. **Оролцогч талуудтай зөвлөлдөх:** Үүнд хиймэл оюун ухаан хөгжүүлэгчид, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн бүлгүүд болон бусад сонирхогч талууд орно. Оролцогч талуудтай зөвлөлдөх нь зохицуулалтыг шударга, үр дүнтэй болгоход тусална.
4. **Хиймэл оюун ухааныг зохицуулах тогтолцоог боловсруулах:** Энэхүү тогтолцоо нь зохицуулах шаардлагатай төрөл бүрийн хиймэл оюун ухааны систем, түүнчлэн өөр өөр төрлийн AI системтэй холбоотой эрсдэлийн янз бүрийн түвшнийг тодорхойлох ёстой. Мөн журмын хэрэгжилтийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлох ёстой.
5. **Бодлого, зохицуулалтын хүрээг байнга хянаж, шинэчилж байх:** Хиймэл оюун ухааны салбар хурдацтай хөгжиж байгаа тул бодлого, зохицуулалтын хүрээ нь уян хатан, дасан зохицох чадвартай байх нь чухал юм. Энэ нь зохицуулалтыг хиймэл оюун ухааны технологийн хөгжилтэй хөл нийлүүлэх боломжийг олгоно.

Монгол улсад хиймэл оюун ухааныг зохицуулах тусдаа хууль гаргах шаардлага хараахан бүрдээгүй байна. Олон улсын туршлага тухайлбал Швейцарийн туршлагыг нэвтрүүлэх нь илүү тохиромжтой болов уу. Швейцарийн засгийн газар хиймэл оюун ухааныг зохицуулах тусдаа хууль гаргахгүй байхаар шийджээ. Үүний оронд засгийн газар одоо байгаа хууль

тогтоомжийг хиймэл оюун ухаанд хэрэглэж, шаардлагатай бол эдгээр хууль тогтоомжийг сонгон тохируулна.

Энэ арга нь хэд хэдэн давуу талтай. Нэгдүгээрт, энэ нь засгийн газарт мэдээлэл хамгаалах, хувийн нуушлал зэрэг салбарт аль хэдийн сайн хөгжсөн хууль эрх зүйн орчинг бий болгох боломжийг олгодог. Хоёрдугаарт, энэ нь хиймэл оюун ухааны технологийн хурдацтай хөгжилд засгийн газарт илүү уян хатан, хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгодог. Гуравдугаарт, нарийн төвөгтэй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй шинэ хууль гаргах шаардлагагүй. Гэсэн хэдий ч энэ аргын сүл талууд бас бий. Нэгдүгээрт, энэ нь янз бүрийн хууль тогтоомжийг нөхөхөд хүргэж болзошгүй бөгөөд энэ нь ойлгомжгүй, дагаж мөрдөхөд хэцүү байж болно. Хоёрдугаарт, энэ нь хиймэл оюун ухааны зарим чухал талуудыг зохих ёсоор зохицуулаагүй гэсэн уг юм.

Ерөнхийдөө Швейцарийн засгийн газар хиймэл оюун ухааныг зохицуулах тусдаа хууль гаргахгүй гэсэн шийдвэр нь зохицуулалтын хэрэгцээ, уян хатан байдал, инновацийн хэрэгцээг тэнцвэржүүлсэн прагматик хандлага юм. Засгийн газар хиймэл оюун ухааны технологийн хөгжлийг сайтар хянаж, шаардлагатай бол хууль эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай болно.

ГУРАВ. ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

3.1 Хүн, хуулийн этгээдэд хамаараах мэдээллийн талаарх хууль, дүрэм

Дэлхийн улс орнууд хүний хувийн мэдээллийн нууцлал хамгаалалтын тухай хууль тогтоомж баталж, энэ чиглэлээр хурдацтай өөрчлөлтийг хийж байна. Эдгээр хууль тогтоомж нь хүний хувийн мэдээллийг зөвхөн тодорхой зорилгоор, эсвэл хуульд заасан үндэслэлээр цуглуулж, боловсруулж, ашиглахын зэрэгцээ мэдээллийг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээг авах, холбогдох дүрэм журмыг батлах зэрэг олон шаардлагыг тухайн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигласан этгээдэд тавих болжээ.

Монгол Улсын хувьд ч энэхүү шаардлагыг хуульчлан 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийг баталсан. Тус хууль нь 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Энэ хуулиар хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хүний хувийн мэдээлэл /цаашид "мэдээлэл" гэх/-ийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад гол зорилт нь оршиж байна.

Хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн салшгүй хэсэг бөгөөд энэ хүрээнд хүмүүс өөрийн хувийн мэдээллийг нууцлах, хамгаалуулах, цаашлаад ямар хувийн мэдээллийг нь хэн цуглуулж, хэрхэн ашиглаж байгааг мэдэх болон хуульд заасны дагуу өөрийн мэдээллийг устгуулах эрхтэй юм.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуультай харилцан уялдаатай үйлчилж, Монгол Улсад кибер аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах цогц тогтолцоог бүрдүүлж байна. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр дараах журам, шаардлагууд батлагдсан. Энэ нь:

- Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам;
- Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ гэдэгт ямар мэдээлэл хамаарахыг улс орнууд тус тусын хуулиараа тодорхойлсон байдаг. Харин манай улсын хувьд дараах мэдээллийг хүний хувийн мэдээлэл гэж тодорхойлсон. Эдгээр нь:

“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн 4 дүгээр зүйлд хүний хувийн мэдээллийг дараах байдаар тодорхойлсон байна. Үүнд:

- "хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;

- "хүний эмзэг мэдээлэл" гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;

- "цахим тодорхойлогч" гэж хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай

болон утасгүй технологийн хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээллийг;

- "Эрүүл мэндийн мэдээлэл" гэж хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг;

Мөн хүний хувийн мэдээлэлд хуульд заасан эмзэг мэдээлэл, эрүүл мэнд, генетик болон биометрик мэдээллийг агуулахаар хуульчилсан байна.

Хүний хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, хуваалцах зорилгоор гадны улс орнууд өгөгдөл хамгаалах олон хууль, дүрэм, журмуудыг баталсан байдаг.

Эдгээр хууль тогтоомж, дүрэм журмуудаас Европын Холбоонд (ЕХ) амьдардаг хувь хүмүүсийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах удирдамжийг тогтоодог хууль эрх зүйн орчин буюу Мэдээлэл хамгаалах ерөнхий журам (GDPR), АНУ-ын Хувийн эрүүл мэндийн мэдээллийн (PHI) нууцлал, аюулгүй байдлыг зохицуулдаг хууль ([HIPAA](#)), Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын стандарт (PCI DSS) буюу кредит, дебит болон бэлэн мөнгөний картын гүйлгээний аюулгүй байдлыг оновчтой болгох, карт эзэмшигчдийг хувийн мэдээллийг буруугаар ашиглахаас хамгаалах зорилготой өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн бодлого, журмын багц зэрэг салбарын онцлог шинж чанараас хамаарсан зохицуулалтыг дагаж мөрдөж байна.

АНУ

АНУ-ын Засгийн газар 2020 онд "хувь хүний таних боломжтой" гэж нэр, SSN, биометрийн мэдээлэл зэрэг "хувь хүний биеийн байцаалтыг ялгах эсвэл хянахад ашиглаж болох" бүх зүйл гэж тодорхойлсон; дангаар нь эсвэл төрсөн огноо, төрсөн газар гэх мэт бусад танигчтай. АНУ-ын засгийн газраас хувь хүний мэдээлэлийг дараахь байдлаар тодорхойлдог.

"Хувь хүний нэр, нийгмийн даатгалын дугаар, биометрийн бүртгэл гэх мэтийг дангаар нь ялгах, илрүүлэхэд ашиглаж болох мэдээлэл, эсвэл тодорхой хувь хүнтэй холбоотой эсвэл холбогдох бусад хувийн болон таних мэдээлэлтэй хослуулсан төрсөн огноо, газар, эхийн охины нэр." <https://www.investopedia.com/terms/p/personally-identifiable-information-pii.asp>

АНУ-ын Эрүүл мэнд, үйлчилгээний газрын (HHS) боловсруулсан өгөгдөл тодорхойлолтод 18 төрлийн таних атрибутыг (Хүснэгт 3.1-д үзүүлсэн) хувь хүнд хамааралгүй буюу тодорхойлох боломжгүй болгохыг шаарддаг.

Хүснэгт 3.1. Шууд болон шууд бус таних атрибут

1. Нэр	10. Эрүүл мэндийн төлөвлөгөө ашиг хүртэгч
2. Төрсөн он сар	11. Бизнесийн лицензийн дугаар
3. Утасны дугаар	12. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар
4. Оршин байгаа хаяг	13. Вэб
5. Факс	14. Төхөөрөмжийн серийн дугаар
6. Нийгмийн даатгалын дугаар	15. Интернет протокол (IP) хаяг
7. И-мэйл хаяг	16. Паспорт эсвэл жолоочийн үнэмлэхний зураг
8. Банкны дансны дугаар	17. Биометрийн танигч
9 Эмнэлгийн бичлэгийн дугаар	18. Аливаа өвөрмөц үнэмлэх

HIPAА нь эдгээр танигчдыг Эрүүл мэндийн хамгаалалттай мэдээлэл (PHI) гэж ангилдаг. Өгөгдөл тодорхойлох аюулгүйн техник нь энгийн бөгөөд зардал багатай боловч ашиглалтын бүх тохиолдолд тохиромжгүй байдаг. Зарим тохиолдолд энэ нь хэт хязгаарлагдмал бөгөөд өгөгдлийг ашиглах боломжгүй болгодог.

Австрали

Хувийн мэдээллийг 1988 оны Хувийн нууцын тухай хуулиар хамгаалдаг. Энэ хууль нь холбооны засгийн газар эсвэл хувийн хэвшлийн байгууллагуудын хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, задруулахыг зохицуулдаг.

Канад

Хувийн мэдээллийг хамгаалах болон цахим баримт бичгийн тухай хууль нь хувийн мэдээллийг арилжааны зорилгоор ашиглахыг зохицуулдаг. Энэ нь дангаараа эсвэл бусад өгөгдөлтэй хослуулан хувь хүн гэж тодорхойлох боломжтой мэдээлэл гэж тодорхойлогддог.

3.2 ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАМААРААХ МЭДЭЭЛЭЛ

Хүний болон хуулийн этгээдийн хувийн мэдээллийг тодорхойлох нь хүний хувийн мэдээллийг бүрдүүлдэг өгөгдлүүд болон аж ахуйн нэгж зэрэг хуулийн этгээдтэй холбоотой өгөгдлийг тодорхойлох явдал юм. Хүний болон хуулийн этгээдийн мэдээлэлд өөр өөр хууль тогтоомж үйлчилдэг.

Хүний болон хуулийн этгээдийн мэдээлэлд дараах өгөглүүдийг төрөлжүүлэн авч үздэг байна. Үүнд:

1. Хүний хувийн мэдээлэл

Хүний хувийн мэдээлэл нь дангаараа эсвэл бусад өгөгдлтэй хослуулан тодорхой хувь хүнийг тодорхойлоход ашиглаж болох аливаа өгөгдлийг хэлнэ. Хүний хувийн мэдээлэл нь дараах төрлийн мэдээллийг агуулах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

Шууд таних мэдээлэл:

- Овог, нэр
- Нийгмийн даатгалын дугаар
- Улсын иргэний бүртгэлийн дугаар
- Жолооны үнэмлэхний дугаар
- Паспортын дугаар

Холбогдох мэдээлэл

- Гэрийн хаяг
 - Гудамжны хаяг
 - Хот, аймаг
 - Дүүрэг, сум
 - Зип код
- Утасны дугаар
 - Гэрийн утасны дугаар
 - Гар утасны дугаар
 - Ажлын газрын утасны дугаар
- Имэйл хаягууд
 - Хувийн имэйл хаяг
 - Ажлын имэйл хаяг
- Онлайн танигч
 - IP хаяг
 - MAC хаяг
 - Күүки
 - Device Identifiers
 - Нийгмийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчийн нэр

Биометрийн мэдээлэл

- Хурууны хээ
- Нүүр царай таних өгөгдөл
- Торлог бүрхэвч
- Дууны өгөгдөл
- ДНХ өгөгдөл

Санхүүгийн мэдээлэл:

- Банкны дансны дугаарууд
- Зээлийн картын дугаарууд
- Орлого, татварын мэдээлэл
- Санхүүгийн гүйлгээний түүх

Эмнэлэг болон эрүүл мэндийн мэдээлэл

- Эмнэлгийн бүртгэл
- Эрүүл мэндийн даатгалын мэдээлэл
- Эмийн жорын мэдээлэл
- Эмчилгээний түүх
- Генетик мэдээлэл

Хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл

- Ажилтны дугаар
- Ажлын туршлага
- Цалингийн мэдээлэл
- Гүйцэтгэлийн үнэлгээ
- Ажлын байрны байршил

Боловсролын мэдээлэл

- Оюутны код
- Дүнгийн мэдээлэл
- Зэрэг

Засгийн газраас олгосон таних өгөгдөл

- Цэргийн бүртгэлийн дугаар
- Татвар төлөгчийн дугаар
- Сонгогчийн бүртгэлийн мэдээлэл

Эмзэг мэдээлэл

- Арьс өнгө эсвэл угсаатны гарал үүсэл
- Улс төрийн үзэл бодол
- Шашны эсвэл гүн ухааны итгэл үнэмшил
- Бэлгийн чиг баримжаа
- Эрүүгийн бүртгэл

Газарзүйн байршлын өгөгдөл

- GPS координат
- Аяллын түүх
- Байршлыг хянах өгөгдөл

Төрөл бүрийн таних мэдээлэл

- Гэрэл зураг
- Видео
- Аудио бичлэг
- Тээврийн хэрэгслийн таних дугаар
- Автомашины улсын дугаар

Дижитал танигч

- Нэвтрэх итгэмжлэл
 - Хэрэглэгчийн нэр
 - Нууц үг
- Аюулгүй байдлын асуулт, хариулт

2. Хуулийн этгээдийн мэдээлэл

Хуулийн этгээдийн мэдээлэл гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллага болон бусад хувь хүн бус байгууллагуудтай холбоотой мэдээллийг хэлнэ. Энэ мэдээлэл нь ихэвчлэн тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, хууль эрх зүйн байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тодорхойлж өгдөг.

Хуулийн этгээдийн мэдээллийн жишээ:

Үндсэн танигч:

- Хуулийн этгээдийн нэр (компанийн нэр)
- Хуулийн этгээдийн таниулбар (LEI)
- Регистрийн дугаар
- Байгуулагдсан огноо
- Татварын дугаар (TIN)

Холбогдох мэдээлэл

- Бизнесийн хаяг
- Бизнесийн имэйл хаяг
- Бизнесийн утасны дугаар

Санхүүгийн мэдээлэл

- Банкны дансны дэлгэрэнгүй мэдээлэл
- Санхүүгийн тайлан
- Зээлийн зэрэглэл
- Татварын тайлан

Үйл ажиллагааны мэдээлэл

- Аж үйлдвэрийн ангилал
- Гол удирдлагууд болон тэдний холбоо барих хаяг
- Ажиллагсдын тоо
- Бизнесийн бүтэц (жишээ нь, ХХК, корпораци)

Хууль эрх зүйн болон нийцлийн мэдээлэл

- Зохицуулалтын мэдүүлэг
- Лиценз, зөвшөөрөл
- Шүүхийн түүх

3.3 Хүн, хуулийн этгээдэд хамаараах мэдээлэллийг тодорхойлох

Дээрх мэдээлэл болон Монгол улсын хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хүн, хуулийн этгээдэд хамаарах дээрх мэдээллийг нэгтгэн хүснэгт 3.2-д хүн, хуулийн этгээдэд хамаарах өгөгдлийг тодорхойллоо.

Хүснэгт 3.2.Хүн, хуулийн этгээдэд хамаарах өгөгдөл

№	ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ	ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАМААРАХ МЭДЭЭЛЭЛ
1.	Хүний үндэс, угсаа,	1 Хуулийн этгээдийн регистр
2.	Шашин шүтлэг,	2 Хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай/
3.	Итгэл үнэмшил	3 Хуулийн этгээдийн нэр
4.	Эрүүл мэнд	4 Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, оршин байгаа хаяг
5.	Захидал харилцаа	5 Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд
6.	Генетик	6 Эцсийн өмчлөгч
7.	Биометрик мэдээлэл	7 Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл
8.	Тоон гарын үсгийн хувийн түлхүүр	8 Үүсгэн байгуулагчийн мэдээлэл
9.	Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх	9 Хуулийн этгээдийн оршин байгаа газрын хаяг, байршил
10.	Бэлгийн болон хүсийн чиг баримжаа, илэрхийлэл	10 Үүсгэн байгуулагдсан огноо
11.	Бэлгийн харьцааны талаарх мэдээллийг	11 Нийгмийн сүлжээ
12.	Хүний эцэг /эх/-ийн нэр	12 Харилцаа холбооны уастай болон утасгүй технологийн хаяг
13.	Өөрийн нэр	13 Бусад төрлийн төхөөрөмж
14.	Төрсөн он, сар, өдөр	14 Татвар төлөгчийн дугаар
15.	Нас	
16.	Төрсөн газар	
17.	Оршин суугаа газрын хаяг, байршил	
18.	Иргэний бүртгэлийн дугаар	
19.	Регистерийн дугаар	
20.	Татвар төлөгчийн дугаар	
21.	Банкны дансны дугаар	
22.	Нийгмийн даатгалын дугаар	
23.	Хөрөнгө	
24.	Боловсрол	
25.	Гишүүнчлэл	
26.	Мэдээллийн системийн нэвтрэх нэр	
27.	Цахим шуудан	
28.	Нийгмийн сүлжээ	
29.	Харилцаа холбооны уастай болон утасгүй технологийн хаяг	
30.	Бусад төрлийн төхөөрөмж	
31.	мэдээллийн систем дэх мэдээллийг	

32.	Хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээлэл		
33.	Хүний бие махбод		
34.	Сэтгэцийн эрүүл мэнд		
35.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тухай мэдээлэл		

Дээр тодорхойлсон (Хүснэгт 3.2 Хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээлэл) мэдээлэлд хувь хүнд хамаарах мэдээлэл – 35, хуулийн этгээдэд хамаарах мэдээлэл – 14 байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилсан. Уг хуулийн 7.3-т “Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ.” гэж заасан нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд тодорхойлсон ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ НЬ ЭНЭХҮҮ Хязгаарлалттай мэдээлэлд хамаарч байна.

Дараах зааврыг мөрдсөнөөр хувийн нууцыг хамгаалах, холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөхийн тулд ямар төрлийн өгөгдлийн эзнийг тодорхойлох нууцлах шаардлагатайг системтэйгээр тодорхойлж чадна. Үүнд:

1. Агуулга, дүрэм журмыг ойлгох

- Зохицуулалтын шаардлага: Өгөгдлийн нууцлалын холбогдох дүрэм журам болон тухайн салбарт хамаарах дагаж мөрдөх дүрэм, журмыг тодорхойлох
- Бизнесийн хэрэгцээ: Бизнесийн тодорхой нөхцөл байдал, өгөгдлийг хэрхэн ашиглах, хадгалах, хуваалцах талаар ойлгох

2. Өгөгдлийн каталог хийх

- Өгөгдлийн эх сурвалжийг тодорхойлох: Өгөгдлийн сан, программ, файл, гуравдагч талын өгөгдөл зэрэг бүх өгөгдлийн эх сурвалжийг каталогжуулах
- Өгөгдлийн зураглал: Өгөгдөл хаана байрлаж байгаа, тэдгээр нь систем хооронд хэрхэн урсаж байгаа, түүнд хэрхэн нэвтэрч байгааг зураглах

3. Өгөгдлийг эмзэг байдлаар нь ангилах

- Хувийн таних мэдээлэл (PII): Хувь хүнийг шууд болон шууд бусаар таних боломжтой өгөгдлийн атрибутыг(нэр, нийгмийн даатгалын дугаар, хаяг гэх мэт) тодорхойлох
- Хувийн эмзэг мэдээлэл (SPI): Нэмэлт хамгаалалт шаарддаг (эрүүл мэнд, санхүүгийн мэдээлэл) илүү эмзэг өгөгдлийг тодорхойлох
- Контекст-тусгай өгөгдөл: Тухайн байгууллагын онцлог нөхцөл байдалд эмзэг гэж тооцогдох бусад аливаа өгөгдлийг (жишээ нь, өмчийн бизнесийн мэдээлэл, хэрэглэгчийн мэдээлэл) тодорхойлох

4. Эрсдлийн үнэлгээ

- Дахин таних эрсдэл: Өгөгдлийг нэргүй болгохгүй бол дахин таних эрсдэлийг үнэл. Өгөгдлийн онцлог байдал, таних тэмдгийг илрүүлж чадах өгөгдлийн элементүүдийн боломжит хослуулд зэрэг хүчин зүйлсийг авч үзэх
- Нөлөөллийн үнэлгээ: Хэрэв нууц мэдээлэл ил гарсан тохиолдолд хувь хүн болон байгууллагад үзүүлэх нөлөөллийг үнэлэх

5. Тодорхойлох боломжгүй болгохын тулд өгөгдлийг эрэмбэлэх

- Mash эмзэг, өндөр эрсдэлтэй: Mash эмзэг бөгөөд дахин танигдах өндөр эрсдэлтэй өгөгдлийг эрэмбэлэх
- Дунд зэргийн эмзэг ба эрсдэл: Дунд зэргийн эмзэг, дунд зэргийн эрсдэлтэй өгөгдлийг оруулах
- Эмзэгшил багатай, эрсдэл багатай: Ашиглалтын тодорхой тохиолдол, зохицуулалтын шаардлагаас хамааран эмзэгшил бага, эрсдэл багатай өгөгдлийг нэрээ нууцлах шаардлагатай эсэхийг анхаарч үзэх

6. Оролцогч талуудтай зөвлөлдөх

- Дотоод оролцогч талууд: Оролцоог хангаж, зохицуулалтыг баталгаажуулахын тулд өгөгдөл эзэмшигчид, хуулийн баг, хариуцах ажилтнууд, мэдээллийн технологийн аюулгүй байдлын багуудтай хамтран ажиллах
- Гадны оролцогч талууд: Дагаж мөрдөх, шилдэг туршлагыг хэрэгжүүлэхийн тулд гадны түншүүд, зохицуулах байгууллага, нууцлалын багтай зөвлөлдөх

7. Баримт бичиг, хяналт

- Баримтжуулалт: Ашигласан үндэслэл, шалгуурыг багтаасан нэрээ нууцлахаар тодорхойлсон өгөгдлийн атрибуутын нарийвчилсан баримт бичгийг бүрдүүлэх
- Хянаж, шинэчлэх: Өгөгдлийн шинэ эх үүсвэр, зохицуулалтын өөрчлөлт, хөгжиж буй бизнесийн хэрэгцээнд дасан зохицохын тулд өгөгдлийн ангилал, нэрээ нууцлах үйл явцыг тогтмол хянаж, шинэчлэх

Хүснэгт 3.3-д Зарим төрлийн өгөгдлийн эмзэг байдлын түвшин, өгөгдлийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох эсэхийг харууллаа.

Хүснэгт 3.3. Өгөгдлийн эмзэг байдлын түвшин

Өгөгдлийн ангилал	Өгөгдлийн атрибуутын жишээ	Эмзэг байдал	Тодорхойлох боломжгүй болгох
Хувийн таних мэдээлэл	Нэр, хаяг, утасны дугаар	Өндөр	Тийм
Санхүүгийн мэдээлэл	{Кредит картын дугаар, банкны данс	Өндөр	Тийм
Эрүүл мэндийн мэдээлэл	Эмнэлгийн бүртгэл, лабораторийн шинжилгээ	Өндөр	Тийм
Хэрэглэгчийн мэдээлэл	Худалдан авалтын түүх, Холбоо барих тохиргоо	Дунд зэрэг	Тийм
Ажилчдын мэдээлэл	Цалин, гүйцэтгэлийн үнэлгээ	Дунд зэрэг	Тийм
Бизнесийн мэдээлэл	Худалдааны нууц, өмчийн мэдээлэл	Өндөр	Тийм
Системийн бүртгэлүүд	IP хаяг, нэвтрэх цаг	Бага, дунд зэрэг	Тийм/Үгүй (агуулгаас хамаарна)

3.3.1 Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох болон шифрлэлтийн аргууд

Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох гэдэг нь хувь хүн, хуулийн этгээдийг шууд таних боломжгүй болгохын тулд өгөгдлийн багцаас хувийн мэдээллийг устгах эсвэл

өөрчлөх үйл явц юм. Энэ нь хувийн нууцыг хамгаалах, ялангуяа судалгаа, шинжилгээ хийх эсвэл олон нийтийн хэрэгцээнд зориулж өгөгдлийг хуваалцах, нийтлэх үед маш чухал юм.

Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгох аргууд

- 1. Өгөгдлийг далдах- Data masking:** Жинхэнэ өгөгдлийг бодит мэт боловч танигдах боломжгүй зохиомол өгөгдлөөр орлуулах. Эмзэг өгөгдөл зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд тэмдэгтүүдийг холих, шифрлэх, санамсаргүй утгуудаар өгөгдлийг солих зэргийг далдах арга техникт ашигладаг.
 - Хэрэглэх тохиолдол: Бодит өгөгдлийг ил гаргахгүйгээр өгөгдлийн бүрэн бүтэн байдал шаардлагатай хөгжүүлэлт, туршилтын орчинд ашиглагддаг.
 - Жишээ: Зээлийн картын дугаарыг санамсаргүй боловч хүчинтэй тоогоор солих замаар далдах
- 2. Өгөгдөл шуугиан нэмэх- Data Perturbation:** Энэ арга нь танигдахаас сэргийлж өгөгдлийг бага зэрэг өөрчлөх явдал юм. Энэ аргад өгөгдлийн утгад шуугиан нэмэх, өгөгдөл солилцох эсвэл анхны өгөгдлийн багцын статистик шинж чанарыг хадгалсан синтетик өгөгдөл үүсгэх зэрэг орно.
 - Хэрэглэх тохиолдол: Нарийвчилсан утгыг оруулах шаардлагагүй статистикийн өгөгдлийн санд ашигладаг.
 - Жишээ: Ажилчдын хувийн мэдээллийг хамгаалахын тулд цалингийн өгөгдөл шуугиан нэмэх
- 3. Ерөнхий болгох- Generalization:** Нарийвчилсан өгөгдлийг илүү өргөн ангилаал эсвэл мужаар солино. Жишээлбэл, тодорхой насыг насын бүлгээр сольж болно, эсвэл тодорхой байршлыг илүү өргөн бүсээр сольж болно. Энэ нь өгөгдлийн хэрэглээг хадгалахын зэрэгцээ дахин таних эрсдлийг бууруулдаг.
 - Хэрэглэх тохиолдол: Тодорхой насыг насын интервалаар сольсон хүн ам зүйн өгөгдөлд хэрэглэнэ.
 - Жишээ нь: "29 нас" гэснийг [20, 30] гэж солих
- 4. Өгөгдөл дараах-Data Suppression:** Дахин таних эрсдэл өндөртэй үед өгөгдлийг бүхэлд нь устгах эсвэл орхих
 - Хэрэглэх тохиолдол: Үр дүнтэй нэрээ нууцлах боломжгүй нууц мэдээлэл бүхий өгөгдлийн багцад ашигладаг.
 - Жишээ нь: Байршилд сууринласан танилтаас урьдчилан сэргийлэхийн тулд өгөгдлийн багц дахь тодорхой зип кодыг устгах
- 5. K-Anonymity:** Бүртгэл бүрийг таних шинж чанаруудын хувьд хамгийн багадаа k-1 бусад бүртгэлээс ялгах боломжгүй гэдгийг баталгаажуулна.
 - Хэрэглэх тохиолдол: Шууд бус танигч ашигладаг өгөгдлийн багцад хэрэглэнэ.
 - Жишээ: Доод тал нь таван хүн ижил төстэй хагас танигчийг хуваалцдаг өгөгдлийг бүлэглэх
- 6. L-олон янз байдал:** Эмзэг атрибут нь дор хаяж 1 сайн илэрхийлэгдсэн утгатай байх замаар k- Anonymity-г сайжруулдаг.
 - Хэрэглэ тохиолдол: k-нэргүй өгөгдлийн багц дахь шинж чанарыг задруулах эрсдлийг бууруулдаг.

- Жишээ: k-нэрээ нууцалсан өгөгдлийн аль ч бүлэгт мэдрэмтгий шинж чанарын хувьд дор хаяж гурван өөр утга байгаа эсэхийг баталгаажуулах
7. **Хуурамч нэршил - Pseudonymization:** Хувийн танигчийг хуурамч танигч эсвэл нууц нэрээр солих. Энэ арга нь өгөгдөл дун шинжилгээ хийх боломжийг олгодог бөгөөд хувийн шинж чанарыг илчлэх эрсдлийг бууруулдаг. Гэсэн хэдий ч хуурамч нэрийн түлхүүрийг мэддэг бол энэ нь буцаах боломжтой. Тухайлбал нэрийг давтагдахгүй кодоор солих
8. Дифференциал нууцлал - **Differential Privacy:** Нууцлалын баталгааг хангахын тулд өгөгдөл эсвэл асуулгын үр дүнд тохицуулсан шуугианыг нэмдэг.
- Хэрэглэх тохиолдол: Статистикийн шинжилгээ болон машин сургалтанд өргөн хэрэглэгддэг.
 - Жишээ: Үнэн зөв нэгдсэн мэдээллийн хангахын зэрэгцээ хувь хүний нууцлалыг хамгаалахын тулд өгөгдлийн багц дээрх асуулгын үр дүнд шуугиан нэмэх
9. Өгөгдлийг нэгтгэх-**Aggregation:** Өгөгдөл нь хураангий статистик эсвэл нэгтгэсэн утгууд. Жишээ нь: Хүний цалингийн мэдээллийг өгөхийн оронд бүлгийн дундаж цалинг ил болгох

Шифрлэлтийн аргууд

Өгөгдлийн агуулах дахь өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хангахын тулд шифрлэлтийн алгоритмуудыг ашигладаг. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг шифрлэлтийн алгоритмуудыг товч тайлбарлай. Үүнд:

1. Advanced Encryption Standard (AES): AES нь үр ашиг, аюулгүй байдлын улмаас өргөн хэрэглэгддэг тэгш хэмт шифрлэлтийн алгоритм. Энэ нь 128, 192, 256 битийн түлхүүрийн уртыг дэмждэг. Энэ нь нэрээ нууцлах аргыг хэрэглэхээс өмнө хувийн таниулбар, санхүүгийн мэдээлэл, эрүүл мэндийн бүртгэл зэрэг эмзэг өгөгдлийг шифрлэхэд ашиглагддаг.

2. RSA (Rivest-Шамир-Адлеман)

Тайлбар: RSA нь шифрлэх, тайлахад хос түлхүүр (нийтийн болон хувийн) ашигладаг тэгш хэмт бус шифрлэлтийн алгоритм. Энэ нь аюулгүй байдлыг найдвартай хангадаг боловч тооцоолол их шаарддаг.

3. Homomorphic Encryption: Энэ нь шифрлэгдсэн өгөгдөл дээр шифрийг тайлах шаардлагагүйгээр тооцоолол хийх боломжийг олгодог. Өгөгдлийн агуулах дахь өгөгдөл дүн шинжилгээ хийх, боловсруулахад нууцлалыг хадгалах, эмзэг мэдээллийг нууцлахын зэрэгцээ шифрлэгдсэн байдлаар ажиллах боломжтой.

4. SHA-256 (Secure Hash Algorithm 256-bit): SHA-256 нь оролтын өгөгдлөөс тогтмол хэмжээтэй 256 битийн хэш утгыг үүсгэдэг криптограф хэш функц юм. Өгөгдлийн талбаруудын хэшийг үүсгэхэд ашигладаг бөгөөд энэ нь өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг хангахын зэрэгцээ өгөгдлийг эзнийг таних боломжгүй болгоно.

Хэрэглээ:

- **Data Masking:** AES болон FPE нь өгөгдлийн форматыг бүрэн бүтэн байлгахын зэрэгцээ эмзэг өгөгдлийг далдахад ихэвчлэн ашиглагддаг.
- **Pseudonymization:** RSA болон токенжуулалтын аргууд нь хувийн мэдээллийг хамгаалахын тулд танигчийг нууц нэрээр сольдог.
- **Secure Data Sharing:** Гомоморф шифрлэлт нь нууц мэдээллийг задруулахгүйгээр өөр өөр орчинд өгөгдлийг аюулгүйгээр хуваалцах, боловсруулах боломжийг олгодог.

Гомоморф шифрлэлтийн хэрэглээ:

- Эрүүл мэнд: Өвчтөний нууцлалыг хадгалахын зэрэгцээ мэдээлэл авахын тулд эмнэлгийн өгөгдлийг найдвартай боловсруулдаг.
- Санхүү: Санхүүгийн эмзэг мэдээллийг ил гаргахгүйгээр эрсдэлийн үнэлгээ, залилан илрүүлэх зэрэг шифрлэгдсэн санхүүгийн тооцооллыг гүйцэтгэх.
- Машин сургалт: Шифрлэгдсэн өгөгдлийн багц дээр загваруудыг сургаж, урьдчилан таамаглах аналитик хийхэд хувийн өгөгдлийг аюулгүй ашиглах боломжийг олгодог.
- Засгийн газар: Засгийн газрын янз бүрийн хэлтэс, агентлагууд хоорондын нууц мэдээллийг найдвартай хуваалцах, дүн шинжилгээ хийх.

Эдгээр шифрлэлтийн алгоритмуудыг ашигласнаар өгөгдлийн агуулахууд өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлын өндөр түвшинд хүрч, нууц мэдээллийг нууцлах явцад хамгаалж чадна.

3.3.2 Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгох аргыг хэрэглэх

Өгөгдлийг хэрэглээ, ямар судалгаанд ашиглахаас хамааран хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох аргыг сонгон ашигладаг. Энд хүснэгт 3.4,

хүснэгт 3.5-д хүн, хуулийн этгээдэд хамаарах өгөгдөл, түүнийг тодорхойлох боломжгүй болгох аргуудыг жишээ болгон орууллаа.

Хүснэгт 3.4 Хүний хувийн мэдээлэлд хамаарах өгөгдлийг тодорхойлох боломжгүй болгох

№	Хүний хувийн мэдээллийн төрөл	Хэрэглэх арга
1.	Хүний үндэс, угсаа	Ерөнхийлөх
2.	Шашин шүтлэг,	Ерөнхийлөх
3.	Итгэл үнэмшил	Ерөнхийлөх
4.	Эрүүл мэнд	Маск хийх Хуурмаг нэрээр солих K-anonymity Дифференциал нууцлал
5.	Захидал харилцаа	Ерөнхийлөх Маск хийх
6.	Генетик	Маск хийх Хуурмаг нэрээр солих K-anonymity Дифференциал нууцлал
7.	Биометрик мэдээлэл	Мэдрэмтгий хэсгийг арилгах, бүдгэрүүлэх, пикселизаци хийх
8.	Тоон гарын үсгийн хувийн түлхүүр	Устгах
9.	Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх	Устгах
10.	Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл	Ерөнхийлөх
11.	Бэлгийн харьцааны талаарх мэдээллийг	Ерөнхийлөх
12.	Хүний эцэг /эх/-ийн нэр	Маск хийх Хуурмаг нэрээр солих
13.	Өөрийн нэр	Маск хийх Хуурмаг нэрээр солих
14.	Төрсөн он, сар, өдөр	Маск хийх
15.	Нас	Ерөнхийлөх K-Anonymity
16.	Төрсөн газар	Ерөнхийлөх
17.	Оршин суугаа газрын хаяг, байршил	Ерөнхийлөх
18.	Иргэний бүртгэлийн дугаар	Кодлох
19.	Регистерийн дугаар	Кодлох
20.	Татвар төлөгчийн дугаар	Хуурмаг нэрээр солих
21.	Банкны дансны дугаар	Хуурмаг нэрээр солих
22.	Нийгмийн даатгалын дугаар	Хуурмаг нэрээр солих
23.	Хөрөнгө	Suppression, L-diversity
24.	Боловсрол	Suppression, L-diversity
25.	Гишүүнчлэл	Suppression, L-diversity
26.	Мэдээллийн системийн нэвтрэх нэр	Кодлох
27.	Цахим шуудан	Маск хийх Хуурмаг нэрээр солих

28.	Нийгмийн сүлжээ	Маск хийх Хуурмаг нэрээр солих
29.	Харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг	Маск хийх Хуурмаг нэрээр солих
30.	Бусад төрлийн төхөөрөмж	Маск хийх Хуурмаг нэрээр солих
31.	Хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээлэл	Маск хийх Хуурмаг нэр
32.	Хүний бие махбод	K-Anonymity
33.	Сэтгэцийн эрүүл мэнд	K-Anonymity
34.	Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авсан тухай мэдээлэл	Маск хийх
35.	Зураг	Мэдрэмтгий хэсгийг арилгах, бүдгэрүүлэх, пикселизаци хийх

Хүснэгт 3.5. Хуулийн этгээдэд хамаарах өгөгдлэтийн тодорхойлох боломжгүй болгох жишиээ

№	Хуулийн этгээдэд хамаарах мэдээлэл	Хэрэглэх арга
1	Хуулийн этгээдийн регистр	Шифрлэх, хуурмаг нэрээр солих
2	Хуулийн этгээдийн хувийн хэргийн дугаар /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай/	Шифрлэх, хуурмаг нэрээр солих
3	Хуулийн этгээдийн нэр	Маск хийх Хуурмаг нэрээр солих
4	Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, оршин байгаа хаяг	Ерөнхийлөх K-Anonymity
5	Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд	Маск хийх Хуурмаг нэрээр солих
6	Эцсийн өмчлөгч	Маск хийх Хуурмаг нэрээр солих
7	Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл	Маск хийх Хуурмаг нэрээр солих
8	Үүсгэн байгуулагчийн мэдээлэл	Маск хийх Хуурмаг нэрээр солих
9	Хуулийн этгээдийн оршин байгаа газрын хаяг, байршил	Ерөнхийлөх Хуурмаг нэрээр солих
10	Үүсгэн байгуулагдсан огноо	Маск хийх
11	Нийгмийн сүлжээ	Маск хийх Хуурмаг нэрээр солих
12	Харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг	Маск хийх Хуурмаг нэрээр солих
13	Бусад төрлийн төхөөрөмж	Маск хийх Хуурмаг нэрээр солих
14	Татвар төлөгчийн дугаар	Хуурмаг нэрээр солих

3.3.3 Их өгөгдлийн сан байгуулах зарим улсын жишиээ

1. Эстони улсын их өгөгдлийн санаачлага

Эстони улс их өгөгдлийн санаачлагыг амжилттай хэрэгжүүлсэн улсын нэг бөгөөд энэ үйл явц нь хэд хэдэн чухал ўе шатыг дамжсан. Эстоний их өгөгдлийн санаачлага хэрхэн хэрэгжсэнийг доорх алхмуудаар тайлбарлай:

Электрон засгийн газар (e-Government)

Эстонийн их өгөгдлийн санаачлагын суурь нь тэдний цахим засгийн газрын тогтолцоо юм. 2001 онд Эстони улс X-Road гэх үндэсний өгөгдлийн солилцооны платформыг нэвтрүүлсэн. Энэ платформ нь төрийн болон хувийн байгууллагуудын хооронд өгөгдлийг аюулгүйгээр хуваалцах боломжийг олгож, их өгөгдлийн сан үүсгэх, ашиглах суурийг тавьсан байна.

Дижитал иргэний үнэмлэх (Digital ID Card)

Эстонийн бүх иргэн дижитал иргэний үнэмлэхтэй бөгөөд энэ нь цахим засгийн газрын үйлчилгээнд хандах үндсэн арга юм. Дижитал үнэмлэх нь иргэдийн мэдээллийг аюулгүй хадгалж, цахим гарын үсэг зурж, бүх төрлийн цахим үйлчилгээнд хандах боломжийг олгосон.

Нээлттэй өгөгдлийн бодлого (Open Data Policy)

Эстони улс нээлттэй өгөгдлийн бодлого баримталж, төрийн байгууллагуудын цуглуулсан өгөгдлийг олон нийтэд нээлттэй болгох арга хэмжээ авсан. Энэ нь судлаачид, бизнес эрхлэгчид, иргэдэд өгөгдөл суурилсан шийдвэр гаргахад тусладаг байна.

Дэд бүтэц ба аюулгүй байдал

Эстони улс өгөгдлийн дэд бүтцэд ихээхэн анхаарч, өгөгдлийн төвүүдийг сайжруулж, өгөгдлийн нөөцийг аюулгүй байлгах арга хэмжээг авсан. Тэд Кибер аюулгүй байдлын арга хэмжээг чангатгаж, өгөгдлийн аюулгүй байдалд анхаардаг.

Иноваци ба хамтын ажиллагаа

Эстони улс технологийн салбарт инновацийг дэмжиж, старт-ап компаниуд, технологийн компаниудтай хамтран ажилладаг. Тэд өгөгдлийн шинжилгээ, машин сургалт, хиймэл оюун ухааны салбарт судалгаа, хөгжүүлэлтийн төсөл хэрэгжүүлж байна.

Үр дүн:

- Ил тод байдал: Төрийн үйл ажиллагааны ил тод байдал нэмэгдсэн.
- Иргэдийн оролцоо: Иргэд төрийн үйлчилгээнд идэвхтэй оролцох боломжтой болсон.
- Эдийн засгийн өсөлт: Технологийн инноваци, стартапуудын өсөлтөөр эдийн засагт зерэг нөлөө үзүүлсэн.
- Аюулгүй байдал: Өгөгдлийн аюулгүй байдлыг хангаж, цахим халдлагаас хамгаалах чадварыг сайжруулсан.

Эдгээр алхмууд нь Эстонийг дэлхийн цахим засгийн газрын манлайлагч болгосон байна. Эстонийн амжилт нь зөвхөн технологийн дэд бүтэц төдийгүй, хууль эрх зүйн орчин, иргэдийн боловсрол, засгийн газрын шийдвэрүүдтэй нягт холбогддог байна.

Нээлттэй портал

Эстонийн нээлттэй өгөгдлийн сан (Estonian Open Data Portal) нь мэдээллийн дата-сетүүдийг нэг дор байрлуулж, хэрэглэгчдэд татаж авах, ашиглах нөхцлийг бүрдүүлдэг байна. Мөн API-аар дамжуулан мэдээлэлд хандах боломжийг олгодог. Эдгээр нь өгөгдлийн хялбар ашиглалт, интеграци, олон төрлийн хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн байдаг.

Нэг дор байрлуулах

Эстонийн нээлттэй өгөгдлийн портал нь олон төрлийн мэдээллийн дата-сетүүдийг нэг дор төвлөрүүлсэн байдаг. Энэ портал нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын

өгөгдлийг нэгтгэж, хэрэглэгчдэд нэг цэгээс хандах боломжийг олгодог. Жишээлбэл, хөдөө аж ахуй, боловсрол, эрчим хүч, эрүүл мэнд, засаглал, тээвэр зэрэг салбаруудын мэдээлэл байршуулсан байна.

API-аар холбох

Эстонийн нээлттэй өгөгдлийн сан нь өгөгдлийг API (Application Programming Interface) ашиглан хандах боломжийг хангадаг. API нь хэрэглэгчдэд өгөгдлийг автоматжуулсан аргаар татаж авах, боловсруулах боломжийг олгодог. Энэ нь өгөгдлийг динамикаар ашиглах, өөр системүүдтэй интеграц хийхэд ихээхэн ач холбогдолтой.

Жишээ:

- **X-Road:** Энэ систем нь төрийн болон хувийн байгууллагуудын хооронд өгөгдлийг аюулгүй, хурдан, найдвартай солилцох боломжийг олгодог. X-Road нь олон төрлийн API-үүдийг дэмжиж, өгөгдлийн хуваарилалт, интеграцийн асуудлуудыг шийдвэрлэдэг.
- **Нээлттэй өгөгдлийн портал:** Порталд хандах API-үүдийг ашиглан хэрэглэгчид өгөгдлийг татаж авч, боловсруулах боломжтой байдаг байна.

Нэгдсэн идентификатор

Эстони улсын нээлттэй өгөгдлийн сангийн дата-сетүүд нь X-Road гэх өгөгдлийн солилцооны платформ ашиглан хоорондоо холбогддог. X-Road нь өгөгдлийг аюулгүй, үр ашигтайгаар хуваалцах, солилцох, нэгтгэх боломжийг олгодог нээлттэй эх сурвалжийн өгөгдлийн солилцооны систем юм. Энэ систем нь төрийн болон хувийн байгууллагуудын өгөгдлийг хооронд нь хялбархан, аюулгүй холбох боломжийг хангадаг.

Гол холбогч түлхүүр

X-Road системийн гол холбогч түлхүүр нь нэгдсэн идентификатор (unique identifier) буюу ID юм. Энэ ID нь хувь хүний мэдээллийг нууцлах, хандах эрхийг хянахад чухал үүрэгтэй. Гол холбогч түлхүүрийг дараах байдлаар хангадаг.

Үүнд:

1. **Криптографийн аргачлалууд:** X-Road нь криптографийн аргачлалуудыг ашиглан өгөгдлийг хамгаалдаг. Энэ нь өгөгдлийн нууцлал, бүтэн байдлыг хангахын тулд олон төрлийн криптографийн алгоритмуудыг ашигладаг.
2. **Цахим гарын үсэг:** Цахим гарын үсэг нь өгөгдлийг илгээгчийн жинхэнэ байдал, өгөгдлийн бүтэн байдлыг баталгаажуулахад ашиглагддаг.
3. **Хандалтын эрхийн хяналт:** Өгөгдөл хэн, ямар нөхцөлд хандахыг хянахын тулд хандалтын эрхийн системийг ашигладаг. Энэ нь өгөгдлийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалдаг.
4. **Псевдонимжуулалт:** Хувь хүний өгөгдлийг нууцлахын тулд псевдонимжуулалтыг ашигладаг. Энэ нь хувь хүний жинхэнэ нэрийг оронд нь псевдоним буюу орлуулалт нэр ашиглах аргачлал юм.

Хувь хүний нууцыг хангах боломжтой холбогч түлхүүр

Хувь хүний нууцыг хангах боломжтой холбогч түлхүүрийг дараах байдлаар хийнэ.

Үүнд:

1. **Псевдонимжуулалт ба анонимжуулалт:** Хувь хүний жинхэнэ нэр, бусад мэдээлийг псевдонимжуулалт болон анонимжуулалт хийх замаар нууцалдаг. Энэ нь жинхэнэ хүний мэдээллийг илрүүлэх боломжгүй болгож өгдөг.
2. **Хувийн өгөгдлийн хамгаалалт:** Хувь хүний өгөгдлийг хамгаалахын тулд тусгай зөвшөөрөлтэй хандалт, криптографийн хамгаалалтыг ашигладаг. Жишээлбэл, ID картыг ашиглах үед зөвхөн тухайн хүнд зөвшөөрөлтэй мэдээлэлд хандах эрхтэй.

- Хандалтын хяналт: Өгөгдөл хандах эрхийг нарийн хянах замаар зөвшөөрөлтэй хэрэглэгчид л өгөгдөл хандах боломжтой болгодог. Энэ нь өгөгдлийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалдаг.

Эдгээр аргачлалууд нь Эстони улсын нээлттэй өгөгдлийн сангудыг аюулгүй, үр ашигтайгаар ашиглах боломжийг олгодог байна.

2. Өмнөд Солонгос Улс

Эрүүл мэндийн мэдээлэл

- Ашигласан арга: K-anonymity, Дифференциал нууцлал
- Эрүүл мэндийн өгөгдлийн төслүүдэд өвчтөний өгөгдлийг хамгаалахад K-anonymity аргыг, статистик-т Дифференциал нууцлалын аргыг ашигладаг.
- Үр дүн: Судалгаанд зориулж эрүүл мэндийн өгөгдлийг ашиглахын зэрэгцээ өвчтөнүүдийн нууцлалыг сайжруулсан.

Засгийн газрын их өгөгдөл

- Ашигласан арга: Өгөгдлийг далдах, ерөнхий болгох
- Их өгөгдлийн анализийг хамарсан засгийн газрын төслүүд нь иргэдийн мэдээллийг нууцлахын тулд эдгээр аргыг ашигладаг.
- Үр дүн: Хувь хүний нууцлалыг алдагдуулахгүйгээр олон нийтийн өгөгдөл амжилттай дүн шинжилгээ хийх

Үндэсний боловсролын мэдээллийн систем (NEIS)

- Ашигласан арга:: Suppression, L-diversity
- NEIS нь боловсролын судалгаа, бодлогын дүн шинжилгээ хийх боломжийг олгохын зэрэгцээ тэдний хувийн мэдээллийг хамгаалахын тулд оюутны бүртгэлийг нууцладаг.
- Үр дүн: Оюутны хувь хүний мэдээллийг ил гаргахгүйгээр боловсролын үр дүн, боловсролын бодлогын үр нөлөөнд дүн шинжилгээ хийхийг зөвшөөрнө.

3. Япон

Боловсролын мэдээлэл:

- Ашигласан арга: Suppression and L-diversity
- Оюутны хувийн нууцыг хамгаалахын тулд боловсролын бүртгэлийг нэргүй болгох
- Үр дүн: Бодлогын шинжилгээ, судалгаанд зориулж боловсролын өгөгдлийг аюулгүйгээр хуваалцах

4. Америкийн Нэгдсэн Улс

Эрүүл мэнд, судалгаа:

- Ашигласан арга: Дифференциал нууцлал.
- Тайлбар: Өгөгдлийн хэрэглээг хангахын зэрэгцээ өвчтөний мэдээллийг нууцлах зорилгоор эрүүл мэндийн судалгаанд өргөн ашигладаг.
- Үр дүн: Эрүүл мэндийн томоохон судалгаанд өвчтөний хувийн мэдээллийг хамгаалах, үнэ цэнэтэй анагаах ухааны судалгаа хийх боломжийг олгодог.

3.4 Хязгаарлалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгож өгөгдлийн агуулах байгуулах шийдэл

3.4.1 Их өгөгдлийн дэд бүтэц

Их өгөгдлийн дэд бүтцийн зорилго нь өгөгдлийг илүү үр дүнтэй, хурдан бөгөөд найдвартай байдлаар удирдах, шинжлэхэд оршино. Энэ нь байгууллагуудыг өгөгдөл дээр суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд туслах явдал юм.

Их өгөгдлийн дэд бүтэц (Big Data Infrastructure) нь их хэмжээний өгөгдлийг цуглуулах, хадгалах, боловсруулах, шинжлэх, удирдах, болон тайлагнаад зориулсан технологийн цогц систем юм. Энэ нь их өгөгдлийн зохицуулалт, интеграци болон дүн шинжилгээ хийхэд шаардлагатай бүх төрлийн техник хангамж, программ хангамж, болон өгөгдлийн сангудаас бүрдэнэ.

Их өгөгдлийн дэд бүтцийг бүрдүүлэхэд дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна.

Үүнд:

1. **Өгөгдлийн хадгалах систем:** Их өгөгдлийг хадгалаад зориулагдсан өгөгдлийн сангуд, файлын системүүд болон объект хадгалах системүүд. Жишээлбэл, HDFS (Hadoop Distributed File System), Amazon S3, Google Cloud Storage гэх мэт.
2. **Өгөгдөл боловсруулах систем:** Өгөгдлийг боловсруулах, өөрчлөх, хуваалцах системүүд. Apache Hadoop, Apache Spark, Flink гэх мэт өгөгдөл боловсруулах платформууд их ашиглагддаг болно.
3. **Өгөгдлийн урсгалын систем:** Бодит цагийн өгөгдлийн урсгалуудыг удирдах, дамжуулах, шинжлэх системүүд. Apache Kafka, Apache Flume гэх мэт өгөгдлийн урсгалын системүүд үүнд орно.
4. **Өгөгдөл шинжлэх багажууд:** Их өгөгдлийг шинжлэх, боловсруулсан үр дүнгүүдийг дүрслэх, тайлагнах системүүд. Apache Hive, Apache Pig, Tableau, Power BI зэрэг шинжилгээний багажууд ашиглагддаг байна.
5. **Өгөгдлийн менежмент ба зохицуулалт:** Өгөгдлийн аюулгүй байдал, нууцлал, удирдлага, зохицуулалтыг хангах системүүд. Apache Ranger, Apache Atlas зэрэг өгөгдлийн менежмент системүүд ашиглагдана.

Их өгөгдлийн сан үүсгэх

Их өгөгдлийг үүсгэхдээ нийгэм, эдийн засгийн төрөлжсөн мэдээллийн сангудаас мэдээллийг татах авах, хооронд нь холбож нэг өгөгдлийн цогц сан болгохын тулд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ.

Үүнд:

1. Өгөгдлийн эх сурвалжуудыг тодорхойлох:
 - Нийгэм, эдийн засгийн мэдээлэл агуулсан төрийн байгууллагууд, судалгааны хүрээлэнгүүд, бизнесийн байгууллагууд зэрэг мэдээллийн эх сурвалжуудыг тодорхойлно.
2. Өгөгдлийн эх сурвалжуудтай холбогдох:
 - API (Application Programming Interface): Өгөгдлийг автоматаар татах авахын тулд API ашиглана.
 - FTP (File Transfer Protocol): Өгөгдлийн файлуудыг татах авахдаа FTP серверүүдийг ашиглаж болно.
 - Вэб скраппинг: Өгөгдөл авах боломжгүй тохиолдолд веб скраппинг аргачлалыг ашиглаж болно.
3. Өгөгдлийн цэвэрлэгээ ба өөрчлөлт:

- Өгөгдлийг цэвэрлэх, засварлах, өөрчлөхөд ETL (Extract, Transform, Load) процесс ашиглана. Өгөгдлийн формат, хэмжээ, нууцлал зэрэг асуудлуудыг зохицуулна.
 - Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд өгөгдлийг боловсруулна. Жишээлбэл, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэх, стандартчилах
4. Өгөгдлийн сангудыг холбох:
- Өгөгдлийн сангудыг холбоодоо өгөгдлийн загварчлал, интеграцийн аргачлалуудыг ашиглана. Жишээлбэл, RDF (Resource Description Framework), SQL (Structured Query Language) ашиглаж болно.
 - Өгөгдлийн сангудын хамаарлыг тодорхойлж, өгөгдлийг нэгтгэнэ. Жишээлбэл, нэгтгэсэн өгөгдлийн индекслэл, гадаад түлхүүрүүдийг ашиглаж холбоо тогтоох
5. Өгөгдлийн хадгалалт ба удирдлага:
- Өгөгдлийг хадгалах системийг сонгож, өгөгдлийг хадгална. Жишээлбэл, өгөгдлийн агуулах (data warehouse) ашиглаж болно.
 - Өгөгдлийн аюулгүй байдал, нууцлал, хувилбар удирдлагыг хангана.
6. Анализ ба тайлагнал:
- Өгөгдлийг шинжлэх, дүн шинжилгээ хийх, тайлан гаргах хэрэгслүүдийг ашиглана. Жишээлбэл, BI (Business Intelligence) хэрэгслүүд, статистик анализын программ хангамжуудыг ашиглаж болно.


Эдгээр алхмуудыг дагаж, нийгэм, эдийн засгийн төрөлжсөн өгөгдлийн сангудаас мэдээллийг татаж авах, хооронд нь холбож нэг өгөгдлийн цогц сан үүсгэх боломжтой. Энэ үйл явцад өгөгдлийн интеграцийн болон менежментийн технологиуд, аргачлалууд чухал үүрэг гүйцэтгэнэ.

3.4.2 Хүн, хуулийн этгээдийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон ХҮР системээр дамжуулах шийдэл

Шийдэл 1. Хүн, хуулийн этгээдийг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон, төрөлжсөн өгөгдлийн агуулах байгуулах

Төрөлжсөн өгөгдлийн сангаас хувь хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй өгөгдөл бүхий өгөгдлийн агуулахыг нууцлал бүхий API ашиглан хоёр шатлалт өгөгдлийн агуулахын архитектураар гүйцэтгэх нь илүү тохиромжтой гэж үзэж байна.

Зураг 3.1-д Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй өгөгдөл бүхий өгөгдлийн агуулахын үүсгэх архитектурыг харуулав.



Зураг 3.1 Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй өгөгдөл бүхий төрөлжсөн өгөгдлийн агуулахын архитектур

Аргачлал

- Төрөлжсөн өгөгдлийн сан руу API ашиглан холбогдож өгөгдлийг авах ба энд өгөгдлийн хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгох үйлдэл хийгдэнэ.
- Сонгосон ETL tools-г ашиглан тодорхойлох боломжгүй болгоа атрибут бүр дээр тохирох аргыг ашиглан хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгох үйлдэл сонгон хийгдэнэ.
- Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болсон өгөгдлийг өгөгдлийн агуулахад хуулна.
- Үүссэн нээлттэй өгөгдлийн сангийн дата-сетүүд нь ХҮР өгөгдлийн солилцооны платформ ашиглан хоорондоо холбогдоно. ХҮР нь систем нь төрийн болон хувийн байгууллагуудын өгөгдлийг хооронд нь хялбархан, аюулгүй холбох боломжийг хангана.
- Өгөгдлийн багцын элементүүд өөр хоорондоо холбогдох гол холбогч түлхүүр нь нэгдсэн идентификатор (unique identifier) байна. Идентификаторээр хүн, хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, татварын дугаар гэх мэт атрибутиг сонгон авах ба эдгээр атрибутиг шифрлэх, хуурмаг нэр оноох аргаар тодорхойлох боломжгүй болгоно.
- Хуурмаг нэр оноох, шифрлэхэд SHA-256 арга болон гомоморф шифрлэлтийн аргыг ашиглах. Гомоморф шифрлэлт нь эмзэг мэдээллийг задруулахгүйгээр өөр өөр орчинд өгөгдлийг аюулгүйгээр хуваалцах, боловсруулах боломжийг олгодог.

Шийдэл 2. Өгөгдлийн нуураас нэгдсэн их өгөглийн агуулах, өгөгдлийн зах үүсгэх


Зураг 3.2-д Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй өгөгдөл бүхий нэгдсэн их өгөгдлийн агуулах үүсгэх архитектурыг харуулав.

Энэ архитектур нь staging area, өгөгдлийн агуулах үүсгэх, өгөгдлийн зах(data mart) үүсгэх гэсэн алхмуудаас тогтоно.

“Staging area” хэсэгт дараах үйлдлүүд хийгдэнэ. Үүнд:

- Өгөгдөл авах: Түүхий өгөгдлийг төрөл бүрийн эх системээс (өгөдлийн сан, файл, API гэх мэт) аваад Staging area -руу оруулна.
- Өгөгдлийн цэвэрлэгээ: Тогтвортгүй байдал, алдаа, давхардлыг арилгахын тулд өгөгдлийг цэвэрлэнэ. Үүнд форматыг стандартчилах, дутуу утгыг боловсруулах, алдаатай өгөгдлийг засах зэрэг орно.
- Өгөгдлийн хувиргалт: Өгөгдлийг өгөгдлийн агуулахад ачаалахад тохиромжтой хэлбэрт шилжүүлдэг. Үүнд өгөгдлийг нэгтгэх, өгөгдлийн төрлийг хөрвүүлэх, бизнесийн дурмийг хэрэгжүүлэх зэрэг орно.
- Өгөгдөл ачаалах: Цэвэрлэсэн, өөрчилсөн өгөгдлийг өгөгдлийн нууранд(data lake) хуулна.

Өгөгдлийн нуураас хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгосон өгөгдлийг цаашид дүн шинжилгээ хийх, тайлагнах зорилгоор өгөгдлийг агуулахад хуулна.



Зураг 3.2 Хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй өгөгдөл бүхий төрөлжсөн өгөгдлийн агуулахын архитектур

Дүгнэлт

- Их өгөгдөл, хиймэл оюун ухааны олон улсын харьцуулсан судалгаагаар Монгол улсын индекс дэлхийн дунджаас доогуур түвшинд байгаа бөгөөд хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн хиймэл оюун ухааны үндэсний стратегийг боловсруулаагүй байна.
- Хиймэл оюуны системийг хөгжүүлэхэд шаардлагатай гол материал болох нээлттэй их өгөгдлийн сан дутмаг хэвээр байна.
- УСХ-ны судалгаагаар төрийн зарим байгууллагууд нууцад хамаарах шалтгаанаар өгөгдлийг нийлүүлэх сонирхолгүй байна.
- Өгөгдлийн сангүүд бүртгэх, үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих, тайлагнах, судалгаа шинжилгээнд ашиглах гэсэн нийтлэг зорилгоор дотроо ашигладаг.
- Энэ судалгаагаар хүн, хуулийн этгээдийн мэдээлэл (их өгөгдлийн санд нийлүүлэх мэдээллийн жагсаалт)-ийг тодорхойлж, түүнийг тодорхойлох боломжгүй болгох аргачлал зөвлөмжийг боловсруулсан.
- Төрд байгаа төрөлжсөн өгөгдлийн сангүүдаас хүн, хуулийн этгээдийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон өгөгдлийн агуулах байгуулах архитектур, шийдлийг боловсруулсан.

Зөвлөмж

- Их өгөгдөл, хиймэл оюун ухааны ухааны хөжлийг хурдасгахын тулд хиймэл оюун ухааны үндэсний стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Өгөгдөл болон дэд бүтцэд хөрөнгө оруулах;
- Өгөгдөл хариуцаж байгаа болон бусад төрийн албан хаагчдын ур чадвар, чадавхийг сайжруулах;
- Хиймэл оюун ухааны талаарх олон нийтийн оролцоо, мэдлэгийг дээшлүүлэх;
- Өгөгдлийн нууцлалын холбогдох дүрэм журам болон тухайн салбарт хамаарах дагаж мөрдөх дүрэм, журмыг нарийвчлан тодорхойлох;
- Тухайн байгууллагын онцлог нөхцөл байдалд эмзэг гэж тооцогдох өгөгдлийг тодорхойлох;
- Хэрэв нууц мэдээлэл ил гарсан тохиолдолд хувь хүн болон байгууллагад үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх;
- Дагаж мөрдөх, шилдэг туршлагыг хэрэгжүүлэхийн тулд гадны түншүүд, зохицуулах байгууллага, нууцлалын багтай зөвлөлдөж байх;
- Ашигласан үндэслэл, шалгуурыг багтаасан өгөгдлийг нууцлахаар тодорхойлсон өгөгдлийн атрибутын нарийвчилсан баримт бичгийг бүрдүүлдэг байх;
- Өгөгдлийн шинэ эх үүсвэр, зохицуулалтын өөрчлөлт, хөгжиж буй бизнесийн хэрэгцээнд дасан зохицохын тулд өгөгдлийн ангилал, өгөгдлийг нууцлах үйл явцыг тогтмол хянаж, шинэчилдэг байх.

---оо---

Их өгөгдлийн (big data) сан Үүсгэхд хүч, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох судалгаа Хавсралт-1

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ, ӨГӨГДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, ӨГДЛИЙН ХАМААРАЛ, ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ

№	Мэдээлэл хариуцагч	Өгөгдлийн сан	Мэдээллийн сангийн зорилго, хамрах хүрээ, түүний ашиглалтыг тодорхойлох	Өгөгдлийн эх сурвалжийг тодорхойлох	Өсөлтийн хэмжээ болон ашиглалтыг хугацаа	Мэдээллийн сангийн буруулсан хувь зүйн чигслэл, дүрэм журам	Бусад мэдээллийн сангаас мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж буй мэдээлэл	Мэдээлэл хариуцагчнаас үндсэн буруулсан хувь зүйн чигслэл, дүрэм журам
1.	Боловсролын Зээлийн сан	Гадаад, дотоод зээд, тэтгэгийн бүртгэлийн сан	Боловчуулалт, дун шинжилгээ, шийдвэр гаргагт, статистик мэдээлэл нэгтгэн гаргахад ашигладаг	Аж ахуйн нэгж, Байгууллага	Хагас жил	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	- Иргэний хаягийн мэдээлэл - Регистрийн дугаар - Иргэний бүртгэлийн дугаар	- Иргэний хаягийн мэдээлэл - Регистрийн дугаар - Гаалийн цахим лавлагагаа
2.	Гаалийн өрөнхий газар	Гаалийн мэдээллийн сан	Монгол Улсын хилээр орж ирж буй бараа, тээврийн хэрэгслийн импорттын буруулэлт, Улсын хилээр гарч буй бараа, тээврийн хэрэгслийн экспорттын буруулэлтийн мэдээллийн бурутгэл	Иргэн Аж ахуйн нэгж, Байгууллага	Сар Улирал Хагас жил Жил Тухай бур	Гаалийн тухай хууль	- Импиртоор орж ирсэн тээврийн хэргээслийн мэдээлэл - Гаалийн цахим лавлагагаа	- Импиртоор орж ирсэн тээврийн хэргээслийн мэдээлэл - Гаалийн цахим лавлагагаа
3.	Гадаадын иргэн харьяатын газар	Гадаад иргэний бүртгэл	Гадаадын иргэдийн бүртгэл, ирсэн шалтгаан, визийн зөвшөөрөл, оршин суух ирсэн, ямар улсаас эрхэлдэг байсан зэрэг мэдээлэл	Иргэн	Тухай бур	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай	9	- Гадаад иргэний бүртгэлийн мэдээлэл

